

Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
1.2. ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО	7
1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	8
1.4. Олборлолт	10
1.5. Ордын геологийн нөөцийн тооцоо	11
Далд уурхайн ажиллах горим	12
1.6. Ордын өнөөгийн байдал	12
1.7. Тоног төхөөрөмж	18
1.8. Дэд бүтэц	29
1.9. Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	31
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	42
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ	45
ТОДОРХОЙЛОЛТ	45
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	47
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	48
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	52
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	53
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	55
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	55
БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	56
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	58
БҮЛЭГ 12. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	60

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	61
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	65
БҮЛЭГ 15.ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	66
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ	68

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Ордын үлдэгдэл геологийн нөөц (2019 оны 01-р сарын 01-ний байдлаар).....	7
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл	8
Хүснэгт 3. I хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.....	10
Хүснэгт 4. II хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.	10
Хүснэгт 5. Ордын анх батлагдсан нөөц	11
Хүснэгт 6 I хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.....	Error!
Bookmark not defined.	
Хүснэгт 7. II хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.	Error!
Bookmark not defined.	
Хүснэгт 8.. Малталт нэвтрэлтийн өрөмдлөг тэсэлгээний ажлын дэлгэрэнгүй.....	15
Хүснэгт 9. Малталт нэвтрэлтэд зарцуулах тэсрэх материалын зарцуулалт	16
Хүснэгт 10. Хүдэр нураалтын өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо.....	17
Хүснэгт 11. 2025 онд хэрэглэх тэсрэх материалын зарцуулалт	17
Хүснэгт 12. УТ-28 маркийн гар өрмийн техникийн үзүүлэлт.....	18
Хүснэгт 13. УВО-0.8 маркийн тэргэнцрийн техникийн тодорхойлолт.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 14. JTP-1.2x1.2P маркийн өргөх төхөөрөмж	Error! Bookmark not defined.

Хүснэгт 15. Далд уурхайн зүтгүүр АРП-4.5-ын техникийн тодорхойлолт **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 16. 39WH-0.94/98 маркийн цахилгаан компрессорын техникийн тодорхойлолт
..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 17. ВМЭ-6 маркийн суурин сэнсний техникийн үзүүлэлт **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 18. ЦНС-38-154 маркийн насосны техникийн тодорхойлолт **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 19. DZD-25 маркийн насосны техникийн тодорхойлолт **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 20. BF-V275 маркийн дизель цахилгаан үүсгүүр..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 21. BF-V165 маркийн дизель цахилгаан үүсгүүр..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 22. Тоо-чанарын тооцооны нэгдсэн үр дүн **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 23. MZG-50 маркийн чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 24. TD75-650 маркийн туузан дамжуулагчийн техникийн үзүүлэлт **Error! Bookmark not defined.**

Хүснэгт 25. *Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй*42

Хүснэгт 26. *Хөрсний эвдрэлийн байдал талбайн хэмжээнд*.....46

Хүснэгт 27. *Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*48

Хүснэгт 28. *Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*.....52

Хүснэгт 29. *Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*
.....53

Хүснэгт 30. *Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хийгдэж ажлын тоо хэмжээ*.....53

Хүснэгт 31. *Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*56

Хүснэгт 32. *Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*58

Хүснэгт 33. *Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр*.....61

Хүснэгт 34. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	65
Хүснэгт 35. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	66
Хүснэгт 36. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	69

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байриул	8
Зураг 2. Төслийн талбайн засаг захиргааны харъяалал	9
Зураг 3. Төслийн талбайн орчны төлөв байдал	9
Зураг 4. I хүдрийн биетийн өнөөгийн байдлын зүсэлт зураг	13
Зураг 5. II хүдрийн биетийн өнөөгийн байдлын зүсэлт зураг	14
Зураг 6. YТ-28 маркийн гар өрмийн машин	18
Зураг 7. Тэргэнцэр УВО-0.8	Error! Bookmark not defined.
Зураг 8. Өргөх машин JTP-1.2x1.2P	Error! Bookmark not defined.
Зураг 9. Далд уурхайн зүтгүүр	Error! Bookmark not defined.
Зураг 10. ЦНС-38-154 маркийн усны насос	Error! Bookmark not defined.
Зураг 11.Цахилгаан хангамжийн схем	Error! Bookmark not defined.
Зураг 12.Хүдрийн баяжигдах шинж чанарын судалгаа	Error! Bookmark not defined.
Зураг 13. Бүтээгдэхүүний овоолго	Error! Bookmark not defined.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч компани	“Хунт-Өгөөж” ХХК	
1.2	Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	1811004053	
1.3	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-016689	
1.4	Ашигт малтмалын төрөл	Хайлуур жонш	
2	Батлагдсан нөөц		
2.1	Бодитой "В" зэргээр	Хүдэр, мян.тн	402.50
		Эрдэс, мян.тн	234.53
2.2	Боломжтой "С" зэргээр	Хүдэр, мян.тн	486.62
		Эрдэс, мян.тн	303.23
2.3	Нийт нөөц (В+С)	Хүдэр, мян.тн	889.13
		Эрдэс, мян.тн	537.76
3	2024 онд олборлосон нөөц		
3.1	Бодитой "В" зэргээр	Хүдэр, мян.тн	36.76
		Эрдэс, мян.тн	20.28
3.2	Боломжтой "С" зэргээр	Хүдэр, мян.тн	8.34
		Эрдэс, мян.тн	4.65
3.3	Нийт нөөц (В+С)	Хүдэр, мян.тн	45.09
		Эрдэс, мян.тн	24.93
4	2025.01.01-ний байдлаарх үлдэгдэл нөөц		
4.1	Бодитой "В" зэргээр	Хүдэр, мян.тн	365.75
		Эрдэс, мян.тн	214.26
4.2	Боломжтой "С" зэргээр	Хүдэр, мян.тн	478.29
		Эрдэс, мян.тн	298.58
4.3	Нийт нөөц (В+С)	Хүдэр, мян.тн	844.03
		Эрдэс, мян.тн	512.83
4.4	МБХЖ-92 маркийн бүхэллэг хайлуур жоншны овоолго	Хүдэр, мян.тн	8.44
		Эрдэс, мян.тн	7.77
4.5	МБХЖ-75 маркийн бүхэллэг хайлуур жоншны овоолго	Хүдэр, мян.тн	6.71
		Эрдэс, мян.тн	5.03
4.6	Бага агуулгатай хүдрийн овоолго	Хүдэр, мян.тн	23.72
		Эрдэс, мян.тн	9.49
5	Далд уурхай		
5.1	Далд уурхайн ашиглалтын технологи	Хоршоолон нураах ашиглалтын систем	
5.2	Далд уурхайн хүрээн дэх геологийн нөөц	мян.тн	568.51
5.3	Хүдрийн хаягдал	%	10.44
5.4	Хүдрийн бохирдол	%	7.54
5.5	Далд уурхайн үйлдвэрлэлийн нөөц	мян.тн	547.55
5.6	Дундаж агуулга	%	55.38
5.7	Хүдэр дэх эрдсийн хэмжээ	мян.тн	303.23
5.8	Далд уурхайн хүчин чадал	мян.тн/жил	150
5.9	Ашиглалтын хугацаа	жил	5
6	Далд уурхайн тоног төхөөрөмжүүд		

6.1	ҮТ-28 маркийн гар өрмийн машин	ш	11	
6.2	JMD-3T маркийн өргөх төхөөрөмж	ш	2	
6.3	Fambition FL07B маркийн утгуурт ачигч	ш	1	
6.4	UK-12 маркийн автосамосвал	ш	2	
6.5	S100D маркийн компрессор	ш	2	
6.6	PZ-3 маркийн бетон шүршигч машин	ш	1	
6.7	DK40-6 маркийн агааржуулалтын сэнс	ш	1	
6.8	DK40-6 маркийн агааржуулалтын сэнс	ш	4	
6.9	ЦНС-38-220 маркийн усны шахуурга	ш	1	
6.10	DZD-25 маркийн усны шахуурга	ш	4	
6.11	НК-400 маркийн калорифер	ш	2	
6.12	Siton DW1-31 маркийн өрмийн машин	ш	1	
6.13	KFU-0.55 маркийн тэргэнцэр	ш	8	
6.14	Howo маркийн 20 тн даацтай автосамосвал	ш	2	
6.15	SD-300N маркийн утгуурт ачигч	ш	2	
7	Бүтээгдэхүүн гаргалт			
7.1	Анхдагч хүдэр дэх хайлуур жоншны агуулга	%	55.4	
7.2	МБХЖ-92 маркийн бүхэллэг хайлуур жоншны гарц	%	18.5	
7.3	МБХЖ-92 маркийн бүхэллэг хайлуур жоншны хэмжээ	мян.тн	109.7	
7.4	МБХЖ-75 маркийн бүхэллэг хайлуур жоншны гарц	%	24.4	
7.5	МБХЖ-75 маркийн бүхэллэг хайлуур жоншны хэмжээ	мян.тн	140.6	
7.6	МФХЖ-97 маркийн хайлуур жоншны баяжмалын гарц	%	32.0	
7.7	МФХЖ-97 маркийн хайлуур жоншны баяжмалын хэмжээ	мян.тн	107.6	
8	Ус хангамж			
8.1	Усны эх үүсвэр	Гүний худаг		
8.2	Усны хэрэглээ	Унд ахуй	мян.м ³	48.6
		Уурхайн технологи		30.6
		Баяжуулах үйлдвэр		294
		Замын тоос дарах		30
		Нийт		403.2
9	Цахилгаан хангамж			
9.1	Цахилгааны эх үүсвэр	Төвийн эрчим хүчний систем		
9.2	Суурилагдсан чадал	Далд уурхай	кВт	416.5
9.3		Баяжуулах үйлдвэр		1069.9
9.4		Ажилчдын хотхон		91.5
9.5		Нийт		1577.8
10	Эдийн засаг			
10.1	Борлуулах бүтээгдэхүүний хэмжээ	мян.тн	357.82	
10.2	МБХЖ-92 маркийн бүхэллэг хайлуур жонш		109.65	
10.3	МБХЖ-75 маркийн бүхэллэг хайлуур жонш		140.59	
10.4	МФХЖ-97 маркийн хайлуур жоншны баяжмал		107.58	
10.5	Бүтээгдэхүүн борлуулах үнэ / МБХЖ-92/	мян.₮/тн	1,085.56	
10.6	Бүтээгдэхүүн борлуулах үнэ / МБХЖ-75/		974.04	
10.7	Бүтээгдэхүүн борлуулах үнэ / МФХЖ-97/		1,400.10	
10.8	Борлуулалтын нийт орлого	тэрбум ₮	406.59	
10.9	Ашиглалтын нийт зардал		221.05	
10.10	Төслийн хөрөнгө оруулалт		34.34	

10.11	1 тн хүдэр олборлон, баяжуулах дундаж өөрийн өртөг	мян.₮/тн	276.60
10.12	Ашигт ажиллагааны индекс (PI)	PI>1	3.37
10.13	Татварын өмнөх ашиг	тэрбум ₮	185.54
10.14	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		42.22
10.15	Татварын дараах цэвэр ашиг		143.31
10.16	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал		161.37
10.17	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа (PbP)	жил	2.15
10.18	Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ (NPV, @10%)	тэрбум ₮	81.54
10.19	Дотоод өгөөжийн норм (IRR)	%	61.44
10.20	Уурхайн ажиллагсдын тоо /дунджаар/	хүн	225
10.21	1 ажилтны сарын дундаж цалин	мян.₮/хүн	3,398.12
10.22	Улсын төсөвт төлөх татвар төлбөр	тэрбум ₮	103.22
10.23	Орон нутгийн төсөвт төлөх татвар төлбөр		1.40
10.24	Татвар, төлбөрийн борлуулалтын орлогод эзлэх хувь	%	26

1.2. ОРДЫН НӨӨЦИЙН ТООЦОО

Монгол улсын эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 09 сарын 06-ны өдрийн хурлын хуралдааны ХХ-20-05 дугаар дүгнэлтийг үндэслэн (Ордын нөөц 2011 оны 06-р дугаар сарын 01-ний байдлаарх) Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордын 1 ба 2 хүдрийн биетийн хэмжээнд дунджаар 56.33 %-ийн СаF2-ийн дундаж агуулгатай нийт В+С зэргээр 193637.17 тн хүдэрт 109080.86 тн хайлуур жонш агуулагдаж байна. Тооцооны дүнд В зэргээр тогтоогдсон .13 %-ийн дундаж агуулгатай 120937.7 тн хүдэр дэх 67877.54 тн хайлуур жонш, С зэргээр тогтоогдсон 56.68 %-ийн дундаж агуулгатай 72699.47 тн хүдэр дэх 41203.32 тн хайлуур жоншны нөөц агуулагдаж буй орд байгааг судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Ордын үлдэгдэл геологийн нөөц (2019 оны 01-р сарын 01-ний байдлаар)

Нөөцийн хэсэглэлийн дугаар	Дундаж		Жинхэнэ талбай	Хэсэглэлийн эзлэхүүн	Хүдрийн хувийн жин	Хүдрийн нөөц,	СаF2 -ын нөөц,
	Зузаан	Агуулга					
м		>/о	м2	м3	тн/м3	тн	Тн
I хүдрийн биет							
I-B-1	1.91	56.94	3100	5924.46	2.8	16588.48	9445.64
I-C-2	1.74	60.55	6130.88	10674.95	2.8	29889.87	18098.51
Дүн 1			9230.88	16599.41		46478.83	27544.15
II хүдрийн биет							
II-B-1	1.75	49.27	10935.16	19118.30	2.8	53531.25	26376.48
II-C-2	1.79	53.51	7631.10	13634.23	2.8	38175.85	20429.77
Дүн 2			18566.26	32752.54		91707.10	46806.25
В зэрэглэлээр	1.78	51.09	14035.16	25042.76	2.8	70119.73	35822.12
С зэрэглэлээр	1.75	56.6	13761.98	24309.18	2.8	68065.72	38528.28

Нийт В+С	1. 76	53.8	27797.14	49351.9 5	2.8	138185.45	74350.4
----------	----------	------	----------	--------------	-----	-----------	---------


1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

“Хунт-Өгөөж” ХХК-ийн “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг ашиглах төсөл” нь Сүхбаатар аймгийн Мөнх-Хаан сумын нутагт орших бөгөөд сумын төвөөс зүүн хойд зүгт 80 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 530 км, Сүхбаатар аймгийн төвөөс баруун хойд зүгт 82 км зайд байрлаж байна.


Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбилцол нь: L-49-34					
MV-016689 (337.57га)	2010-10-15	30	1	112° 49' 57.14"	47° 14' 26.76"
			2	112° 48' 37.14"	47° 14' 26.76"
			3	112° 48' 37.15"	47° 15' 31.76"
			4	112° 49' 57.15"	47° 15' 31.76"


Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршил



Зураг 2. Төслийн талбайн засаг захиргааны харъяалал



Зураг 3. Төслийн талбайн орчны төлөв байдал



Далд уурхайн үндсэн /босоо гол ам, квершлаг/ ба бэлтгэл /штрек/ малталтыг хоосон чулуулаг дундуур нэвтрэх тул ямар нэгэн нөөцийн блокт хамааруулах боломжгүй юм. Босоо гол амыг хүдрийн биетийн хэвтээ талд газрын гадарга дээрх хүдрийн биетийн гаршаас 25 м зайд хоосон чулуулаг дундуур нэвтэрнэ. Харин тээврийн штрекийг ашиглалтын түвшин бүрт хүдрийн биетийн хэвтээ контактаас 5 м зайд хүдрийн биеттэй параллелиар хоосон чулуулаг дундуур нэвтэрнэ. Харин квершлаг малталтыг босоо гол амнаас тээврийн штрек малталтад перпиндикуляраар хоосон чулуулаг дундуур нэвтэрнэ. Малталтаас гарах хоосон чулуулгийн хэмжээ:

- Босоо гол амыг $S=9.1 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 300 м малталт нэвтэрнэ. $V=s*l=9.1*300=2730 \text{ м}^3$
- Квершлаг малталтыг $S=6.5 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 430 м малталт нэвтэрнэ. $V=s*l=6.5*430=2795 \text{ м}^3$
- Штрек малталтыг $S=6.5 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 410 м малталт нэвтэрнэ. $V=s*l=6.5*410=2665 \text{ м}^3$
- Орт малталтыг $S=6.5 \text{ м}^2$ хөндлөн огтлолын талбайтайгаар нийт 50 м малталт нэвтэрнэ. $V=s*l=6.5*50=325 \text{ м}^3$

Малталт нэвтрэлтийн ажлаас нийт $2730+2795+2665+325=8515 \text{ м}^3$ хөрс гарна.

1.4.Олборлолт

“Хунт Өгөөж” ХХК нь 2025 онд I ба II хүдрийн биетийн далд уурхайн 3 ба 4-р түвшингүүдэд малталт нэвтрэлт, хүдэр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 3.I хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.

№	Малталтууд	Хөндлөн огтлолын талбай, м^2	Малталтын урт, м
1	Босоо гол ам №1	9.1	20
2	Агааржуулалтын босоо гол ам №2	9.1	113
3	Квершлаг	6.5	200
4	Штрек	6.5	230

Хүснэгт 4.II хүдрийн биетийн далд уурхайд дараах малталтуудыг нэвтэрнэ.

№	Малталтууд	Хөндлөн огтлолын талбай, м^2	Малталтын урт, м
---	------------	------------------------------------------	------------------

1	Босоо гол ам №2	9.1	43
2	Агааржуулалтын босоо гол ам №2	9.1	124
3	Квершлаг	6.5	200
4	Штрек	6.5	180

I хүдрийн биетийн далд уурхайгаас 23.12 мян.тн хүдэр, II хүдрийн биетийн далд уурхайгаас 14.47 мян.тн хүдэр олборлоно.

Баяжуулалт: Уурхайгаас олборлосон хүдрээ гар аргаар ялгалт явуулна. 2025 онд 37.60 мян.тн хүдэр олборлон гар аргаар ялгалт хийж ФК-92 маркийн бүхэллэг баяжмал 7.519 мян.тн, ФК-75 маркийн бүхэллэг баяжмал 9.023 мян.тн, бага агуулгатай хүдэр 17.670 мян.тн-ыг ялган авна.

Эдийн засаг: 2024 онд уурхайд 56-н ажилтан ажиллана. ФК-92 ба ФК-75 маркийн баяжмалыг БНХАУ-д борлуулах бол бага агуулгатай хүдрийг дотооддоо баяжуулах үйлдвэрт борлуулна. 2025 онд нийт 14474.36 сая.төг-ийн борлуулалт хийж 10210.83 сая.төг-ийн зардал гарган ажиллана.

1.5.Ордын геологийн нөөцийн тооцоо

Бүдүүн-Ухаа нэртэй хайлуур жоншны ордын 1 ба 2 хүдрийн биетийн хэмжээнд дунджаар 56.33 %-ийн CaF₂-ийн дундаж агуулгатай нийт В+С зэргээр 193637.17 тн хүдэрт 109080.86 тн хайлуур жонш агуулагдаж байна. Тооцооны дүнд В зэргээр тогтоогдсон 56.13 %-ийн дундаж агуулгатай 120937.7 тн хүдэр дэх 67877.54 тн хайлуур жонш, С зэргээр тогтоогдсон 56.68 %-ийн дундаж агуулгатай 72699.47 тн хүдэр дэх 41203.32 тн хайлуур жоншны нөөц агуулагдаж буй орд байгааг судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 5. Ордын анх батлагдсан нөөц

Нөөцийн хэсэглэлийн дугаар	Дундаж		Жинхэнэ талбай м ²	Хэсэглэлийн эзлэхүүн м ³	Хүдрийн хувийн жин тн/м ³	Хүдрийн нөөц тн	CaF ₂ -ын нөөц тн
	Зузаан	Агуулга					
	м	%					
I хүдрийн биет							
I-B-1	1.80	61.57	13385.45	24073.73	2.8	67406.45	41501.06
I-C-2	1.70	60.17	7237.38	12329.86	2.8	34523.62	20773.55
Дүн 1			20622.83	36403.60		101930.07	62274.61
II хүдрийн биет							

II-B-1	1.75	49.27	10935.1 6	19118.30	2.8	53531.25	26376.48
II-C-2	1.79	53.51	7631.10	13634.23	2.8	38175.85	20429.77
Дүн 2			18566.2 6	32752.54		91707.10	46806.25
B зэрэглэлээр	1.78	56.13	24320.6 1	43192.04	2.8	120937.7 0	67877.54
C зэрэглэлээр	1.75	56.68	14868.4 8	25964.10	2.8	72699.47	41203.32
Нийт B+C	1.76	56.33	39189.0 9	69156.13	2.8	193637.1 7	109080.8 6

Далд уурхайн ажиллах горим

- Жилийн нийт хоног 365 хоног
- Үндэсний баяр, ёслолын хоног 14 хоног
- Засвар үйлчилгээ, бусад 51 хоног
- Уурхайн жилд ажиллавал зохих хоног 300 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 3 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг тус тус байна.

1.6. Ордын өнөөгийн байдал


“Хунт-Өгөөж” ХХК нь Бүдүүн-Ухаагийн хайлуур жоншны ордод 2012 онд хайгуулын ажил гүйцэтгэж ЭБМЗ-ийн 2013 оны 07-р сарын 02-ны өдрийн ХХ-13-07 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2013 оны 08-р сарын 06-ны өдрийн н/319 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой болон боломжтой (B+C) зэргээр 56.33 % дундаж агуулгатай 193.63 мян.тн хүдэр Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

Ордын батлагдсан геологийн нөөцөд тулгуурлан 2013-2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж 56.08 %-ийн дундаж агуулгатай 136.3 мян.тн хүдэр олборлож нөөц багассан тул “Хунт-өгөөж” ХХК өөрийн хөрөнгөөр 2020-2023 онд нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэн ЭБМЗ-ийн 2025 оны 03-р сарын 14-ний өдрийн ХХ-05-04 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2025 оны 05-р сарын 28-ний өдрийн н/46 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой ба боломжтой (B+C) зэргээр 60.48 %-ийн дундаж агуулгатай 889.12 мян.тн хүдрийн нөөцийг тодотгон тооцож Улсын нөөцийн нэгдсэн санд шинээр бүртгүүлсэн. Энэхүү нөөцөөс 2024 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж 55.58 %-ийн дундаж

агуулгатай 45.09 мян.тн хүдэр олборлосон. Тус олборлосон хүдрийг гар аргаар ангилан ялгаж, МБХЖ-92, МБХЖ-75 маркийн баяжмал, бага агуулгатай хүдэр ялган борлуулсан. Уурхай дээр 2025.01.01-ний байдлаар МБХЖ-92 маркийн 8.44 мян.тн, МБХЖ-75 маркийн 6.71 мян.тн, бага агуулгатай 23.72 мян.тн хүдэр борлуулаагүй үлдсэн.

“Хунт-Өгөөж” ХХК нь тус ордыг 2013-2024 онуудад 1080 м-ийн түвшин хүртэл далд уурхайн аргаар ашигласан. I хүдрийн биетийн дагуу нийт 80 м гүнтэй хоёр босоо гол ам, 80 м квершлаг, 1120 м штрек, 60 м орт, 610 м восстающий малталтуудыг нэвтэрсэн.


Зураг 4. I хүдрийн биетийн өнөөгийн байдлын зүсэлт зураг



Хүснэгт 6. 2013-2024 онд нэвтэрсэн малталтын урт

№	Малталтын нэр	Хэмжих нэгж	Тоон утга
1	Босоо гол ам	м	160
2	Квершлаг	м	80
3	Штрек	м	1120
4	Восстающий	м	610
5	Орт	м	60
6	Нийт	м	2030

Зураг 5. Далд уурхайн дагуу зүсэлт /I хүдрийн биетийн хойд хэсэг/



Уулын ажлын горим

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагаас төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу дараах байдлаар төлөвлөсөн. Энд:

1-р хүснэгт. Далд уурхайн ажиллах горим

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	15
3	Сул зогсолт	хоног	50
4	Уурхайн ажиллах хоног	хоног	300
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
6	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Далд уурхайн нээлт

Далд уурхайн налуу гол амыг газрын гадаргын X-5234591.9, Y-638191.2, Z-1152 м-ийн солбицлоос 8⁰ налуутайгаар 980 м-ийн түвшин хүртэл 1400 м урттай налуу малталт нэвтэрнэ.

Налуу гол амнуудыг S=12.5 м² хөндлөн огтлолын талбайтайгаар агуулагч чулуулаг дундуур нэвтрэх ба хүдрийн биетийн суналд перпендикуляр байдлаар хүдрийн биетийг бүрэн огтолож өнгөртөл нэвтэрнэ. Налуу гол амнаас ашиглалтын түвшин бүрд хүдрийн биетийн суналын дагуу хоёр тийш мөн адил хөндлөн огтлолын талбайтай тээврийн штрекийг нэвтэрч хүдрийн биетийг нээгч бэлтгэл малталт болох орт малталт нэвтэрнэ.

Хүснэгт 7. Үндсэн гол амнуудын үзүүлэлт

№	Нээгч малталтын нэр	Малталтын нийт урт, м	Солбицол	Хөндлөн огтлолын талбай, м ²	Жилийн хүчин чадал, мян.тн
1	Агааржуулалтын босоо гол ам №1	180	X-5234370.4 Y-638260.9	9.62	50.0
2	Агааржуулалтын босоо гол ам №2	180	X-5235248.4 Y-638112.9	9.62	50.0
3	Налуу гол ам	140	X-5234591.9 Y-638191.2	12.5	150.0

Ашиглалтын дараалал: Тус уурхайн ашиглалтын эхний жилд хүдэр олборлолтын ажлыг босоо гол амаар гүйцэтгэх ба налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг эхлүүлнэ. Ашиглалтын II жилээс налуу гол амаар хүдэр олборлолтын ажлыг гүйцэтгэнэ. Мөн уурхайн олборлолтод өртөөгүй үлдсэн боломжтой (С) зэргийн нөөцийн зэргийг ахиулах, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор ашиглалтын IV, V жилүүдэд хайгуулын малталт нэвтрэнэ.

2026 он: Уурхайн ашиглалтын эхний жилд уурхайд 900 м налуу гол ам нэвтрэх ба хүдэр олборлолтын ажил 1060 м-ийн түвшинд явагдана. Эхний жилд хүдэр олборлолтын ажлыг босоо гол амаар гүйцэтгэх тул босоо гол амнуудыг үргэлжлүүлэн 980 м-ийн түвшин хүртэл 100 м нэвтрэнэ. Уурхайн 1100 м-ийн түвшинд 50 м штрек, 1060 м-ийн түвшинд 130 м квершлаг 1400 м штрек, 80 м орт, 440 м восстающий малталтуудыг нэвтрэнэ. Мөн 1100 м-ийн түвшний В'-1, В'-2, 1060 м-ийн түвшний В'-105, В'-106, В'-107, В'-108, В'-109, В'-110 блокуудаас 50.0 мян.тн хүдэр олборлоно. Мөн өмнөх онуудын үлдэгдэл баяжмалын овоолгуудыг борлуулна.

Хүснэгт 8. Малталт нэвтрэлтийн өрөмдлөг тэсэлгээний ажлын дэлгэрэнгүй

№	Үзүүлэлт	Босоо гол ам	Налуу гол ам	Квершлаг	Штрек	Орт	Восстающий	
1	Малталтын хөндлөн огтлолын талбай, м ²	9.62	12.5	12.5	12.5	10.1	4.0	
2	Шпурын тоо, ш	Цөмлөх	4	5	5	5	4	2
3		Нураах	8	14	14	14	8	
4		Хэв засах	14	19	19	19	17	10
5		Нийт	26	38	38	38	29	12
6		Цөмлөх	2.0	3.3	3.3	3.3	3.3	1.8
7	1 шпурын гүн	Нураах	1.8	3.0	3.0	3.0	3.0	
8		Хэв засах	1.8	3.0	3.0	3.0	3.0	1.8
9		Цөмлөх	8	17	17	17	13	4
10	Нийт шпурын гүн, м	Нураах	14.4	42.0	42.0	42.0	24.0	
11		Хэв засах	25.2	57.0	57.0	57.0	51.0	18.0

12		Нийт	47.6	115.5	115.5	115.5	88.2	21.6
13	1 шпур дэх цэнэгийн жин, кг	Цөмлөх	1.5	2.4	2.4	2.4	2.4	1.2
14		Нураах	1.2	2.0	2.0	2.0	2.1	
15		Хэв засах	1.2	2.0	2.0	2.0	2.1	1.2
16	Нийт цэнэгийн жин, кг	Цөмлөх	6.0	12.0	12.0	12.0	9.6	2.4
17		Нураах	9.6	28.0	28.0	28.0	16.8	
18		Хэв засах	16.8	38.0	38.0	38.0	35.7	12.0
19		Нийт	32.4	78.0	78.0	78.0	62.1	14.4
20	1 шпурын түгжээсний урт, м	Цөмлөх	0.5	0.9	0.9	0.9	0.9	0.6
21		Нураах	0.6	1.0	1.0	1.0	0.9	
22		Хэв засах	0.6	1.0	1.0	1.0	0.9	0.6
23	1 м шпурт ногдох уулын цулын хэмжээ, м ³ /м		0.32	0.30	0.30	0.30	0.32	0.30
24	1 м ³ уулын цулд ноогдох өрөмдлөгийн хэмжээ, м/м ³		3.09	3.30	3.30	3.30	3.12	3.38
25	Нэг мөчлөг дэх мөргөцгийн ахилтын хэмжээ, м		1.6	2.8	2.8	2.8	2.8	1.6
26	1 удаагийн тэсэлгээгээр нурах уулын цулын хэмжээ, м ³		15.39	35.0	35.0	35.0	28.3	6.4
27	Нийт уулын ажлын хэмжээ, м		200	900	130	1450	80	440
28	Мөчлөгийн нийт тоо, удаа		125	321	46	518	29	275
29	Тэсрэх бодисын нийт зарцуулалт, тн		4.05	25.07	3.62	40.39	1.8	3.96
30	Тэсрэх бодисын хувийн зарцуулалт, кг/м ³		2.11	2.2	2.2	2.2	2.20	2.25

Хүснэгт 9. Малталт нэвтрэлтэд зарцуулах тэсрэх материалын зарцуулалт

№	Үзүүлэлт	Үндсэн малталт нэвтрэлт	Бэлтгэл малталт нэвтрэлт	Нийт
1	Нийт өрөмдлөгийн урт, мян.м	48.44	68.27	116.71
2	Нийт тэсрэх бодисын зарцуулалт, тн	32.74	46.13	78.87
3	Нонель систем, шир	17228.6	23807.1	41036
4	Цахилгаан тэслүүр /ЭД/, шир	2464.3	4107.1	6571
5	Цочир дамжуулах шижим /ДША/, м	9857.1	16428.6	26286
8	Малталт нэвтрэлтээс гарах хөрс, мян.м ³	14.8	18.93	33.73

Хүдэр нураалтын ажлын технологи: Мөргөцөгт шпур өрөмдөх ажлыг 2-4 хүний бүрэлдэхүүнтэйгээр гар перфератораар ӨТА-ын паспортын дагуу хийж гүйцэтгэнэ. Мөргөцөгт шпур өрөмдөж дууссаны дараа ээлжийн мастерын зөвшөөрлийн дагуу тэсрэх материалыг авч мөргөцгийг цэнэглэж бусад мөргөцгөөс хүмүүсийг гаргаж тэсэлгээний ажлыг явуулна.

Тэсэлгээний ажлын дараа уурхайн ээлжийн мастер, тухайн ээлжийн ахлагчийн хамт агааржуулалтын байдлыг шалгаж ачилтын орт малталтаас хүдрийг ачигч машинаар тэргэнцэрт ачиж ашиглалтын системийн дагуу блок дахь сийрэгжсэн хүдрийг суулгаж

дараагийн ээлжийг мөргөцөгт шпур өрөмдөх ажлыг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ дарааллаар хүдэр нураалтын ажлын цикл үргэлжилнэ.


Хүснэгт 10. Хүдэр нураалтын өрөмдлөг тэсэлгээний ажлын тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Нураах хүдрийн үеийн өргөн, м	м	1.8
2	Нураах үеийн дундаж өргөн	м	1.8
3	Нураах үеийн хөндлөн огтлолын талбай	м ²	3.24
4	Шпурын диаметр	мм	42
5	Шпурын тоо	ш	12
6	1 шпурын урт	м	1.8
7	Өрөмдлөгийн нийт урт	м	21.6
8	Нэг шпур дэх цэнэгийн урт	м	1.2
9	Нийт цэнэгийн урт	м	14.4
10	Нэг удаагийн тэсэлгээнд орох ТБ-ын зарцуулалт	кг	14.4
11	Шпур ашиглалтын коэф	-	0.94
12	ТБ-ын хувийн зарцуулалт	кг/м ³	2.61
13	Нэг цикл дэх мөргөцгийн ахилт	м	1.7
14	Нэг циклээс гарах уулын цулын хэмжээ	м ³	5.5
15	1м ³ уулын цулд оногдох шпурын урт	м	3.92
16	1м шпурээс гарах уулын цул	м ³	0.26
Нийт ордын хэмжээнд			
17	Нийт уулын ажлын хэмжээ	мян.м ³	18.03
18	Мөчлөгийн нийт тоо	удаа	3273
19	Нийт шпур өрөмдөх хэмжээ	мян.м	70.70
20	Нийт ТБ-ын зарцуулалт	тн	47.13
21	Нонель систем	шир	39276
22	Цахилгаан тэслүүр /ЭД/	шир	16365
23	Цочир дамжуулах шижим /ДША/	м	32730

Хүснэгт 11. 2025 онд хэрэглэх тэсрэх материалын зарцуулалт

№	Малталтын нэр	Өмнөх жилүүдэд	Тухайн жилд	Нийт
		нэвтэрсэн малталтын урт	нэвтрэх малталтын урт	нэвтэрсэн малталтын урт
		м	м	м
1	Налуу гол ам		900	900
2	Агааржуулалтын босоо гол ам	160	200	360
3	Квершлаг	80	130	210
4	Штрек	1120	1450	2570
5	Восстающий	610	80	690
6	Орт	60	440	500
7	Нийт	2030	3200	5230

Зураг 6. 2026 оны ашиглалтын зүсэлт зураг



1.7. Тоног төхөөрөмж

Хүснэгт 12. YТ-28 маркийн гар өрмийн техникийн үзүүлэлт

№	Техникийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Штангны диаметр	мм	22
2	Өрмийн хошууны диаметр	мм	42
3	Бүлүүрийн явалт	мм	40
4	Шпурын гүн	м	3 хүртэл
5	Цохилтын энерги	Ж	50
6	Эргэлтийн момент	Н*м	20
7	Хийн зарцуулалт	м ³ /мин	3.3
8	Хийн даралт	МПа	0.35-0.63
9	Хийн хоолойн дотоод диаметр	мм	19
10	Усны хоолойн дотоод диаметр	мм	13
11	Усны зарцуулалт	л	3.0-4.8
12	Жин	кг	24

Зураг 7. YТ-28 маркийн гар өрмийн машин



Өрмийн суурин машин: Далд уурхайн үндсэн болон бэлтгэл малталтуудын хөндлөн огтлолын талбай, нэвтрэлтийн урт зэрэг хэмжээснүүдээс хамааруулан малталт нэвтрэлтийн ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн DW1-31 маркийн өрмийн машиныг малталт нэвтрэлтийн ажилд хэрэглэхээр сонгосон. Энэхүү өрмийн машин нь хэвтээ налуу малталтуудад хэрэглэдэг, өрөмдлөгийн бүтээл өндөртэй зэргээрээ бусад өрмийн машинуудаас давуу талтай юм.

Зураг 8. Өрмийн машины техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Цооногийн диаметр	мм	41-76
2	Өрөмдлөгийн гүн	м	3.4-4.6
3	Өрөмдлөгийн үед шаардлагатай усны зарцуулалт	л/мин	80
4	Өрмийн төхөөрөмжийн овор хэмжээ: -Урт -Өргөн -Өндөр	мм	12135 2050 2800
5	Жин	тн	13.2
6	Эргэлтийн хурд	мин ⁻¹	0-210
7	Эргэлтийн радиус -дотоод -гадаад	мм	3030 5050
8	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	40

Зураг 9. DW1-31 маркийн өрмийн машин



Хүснэгт 13. JMD-3T маркийн өргөх төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоон утга
1	Өргөлтийн өндөр, м	150
2	Дамрын тоо	1
3	Дамрын диаметр, мм	1000
4	Дамрын өргөн, мм	1200
5	Канатны диаметр, мм	20
6	Дамрыг канатаар ороох тоо, удаа	50
7	Хурд, м/с	1.57-2.4
8	Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	20
9	Цахилгаан хөдөлгүүрийн эргэлт, эрг/мин	200
10	Статик татах хүч, кН	50
11	Өргөх машины урт, өргөн, өндөр, мм	2450x1650x1200
12	Жин, кг	4850

Зураг 10. JMD-3T маркийн өргөх төхөөрөмж



Далд уурхайн уулын цулыг тээвэрлэх тоног төхөөрөмж: Далд уурхайн жилийн хүчин чадал малталтуудын хөндлөн огтлолын талбай зэргийг үндэслэн хүдэр олборлолт болон малталт нэвтрэлтээс гарах хоосон чулуулгийг ухаж ачихад 3.0 м³ утгуурын багтаамжтай Fambition фирмийн FL07B маркийн ачигч машин, 12 тн даацтай UK-12 маркийн автосамосвал ашиглана.

Далд уурхайн эхний жилд налуу гол ам нэвтрэлтийн ажил гүйцэтгэх тул хүдэр олборлолт, тээвэрлэлтийн ажлыг босоо гол амаар гүйцэтгэх тул KFU-0.55 маркийн тэргэнцэр, CJY-3 маркийн цахилгаан зүтгүүрийг үргэлжлүүлэн ашиглана.

Хүснэгт 14. CJY-3 маркийн цахилгаан зүтгүүрийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Масс	тН	3
2	Татах хүч	кН	8.4
3	Дугуй хоорондын зай	мм	600
4	Хөдөлгүүрийн чадал	кВт	12
5	Хамгийн их хурд	км/цаг	10.6
6	Урт	мм	2700
7	Өргөн	мм	1100
8	Өндөр	мм	1500
9	Эргэлтийн хамгийн бага радиус	м	5.5

Зураг 11. CJY-3 маркийн цахилгаан зүтгүүр



Хүснэгт 15. KFU-0.55 маркийн тэргэнцрийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга	
1	Тэвшний багтаамж	м ³	0.55	
2	Даац	тН	2	
3	Овор хэмжээ	Өргөн	мм	850
4		Урт	мм	1600
5		Өндөр	мм	1150
6	Дугуй хоорондын зай	мм	600	
7	Дугуйн диаметр	мм	300	
8	Жин	кг	300	

Зураг 12.. KFU-0.55 маркийн тэргэнцэр



Хүснэгт 16. FL07B маркийн ачигч машины техникийн тодорхойлолт

№	Техникийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Утгуурын багтаамж	м ³	3.0
2	Ачаа даах	тн	6.0
3	Ачих хамгийн их өндөр	м	4.6
4	Явах ангийн урт	м	9.0
5	Явах ангийн өргөн	м	2.3
6	Их биеийн өндөр	м	2.3
7	Явах хамгийн их хурд	км/цаг	25.8
8	Хөдөлгүүрийн чадал	кВт /м.х/	160 /215/
9	Жин	тн	6.4
10	Түлш зарцуулалт	л/цаг	30.0
11	Өгсөх налуу	град	25
12	Хамгийн бага эргэлтийн радиус	м	3.0

Зураг 13. FL07B маркийн ачигч машин



Хүснэгт 17. UK-12 маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Техникийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Тэвшний багтаамж	м ³	6.0
2	Ачаа даац	тн	12.0
3	Явах ангийн урт	м	7.6
4	Явах ангийн өргөн	м	1.9
5	Их биеийн өндөр	м	2.3
6	Явах хамгийн их хурд	км/цаг	23.0
7	Хамгийн бага эргэх радиус (дотор/гадна)	м	4.5/7.2
8	Жин	тн	13.5
9	Түлш зарцуулалт	л/цаг	15
10	Өгсөх налуу	градус	14
11	Буулгах өнцөг	градус	40
12	Хөдөлгүүрийн чадал	кВт /м.х/	119 /160/

Зураг 14. UK-12 маркийн автосамосвал



Зураг 15. S100D маркийн хийн шахуурга



Хүснэгт 18. S100D маркийн цахилгаан компрессорын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Хүчин чадал	м ³ /мин	41
2	Шахсан хийн даралт	МПа	25
3	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	70
4	Хүчдэл	В	380
5	Ажлын дугуйн эргэлтийн давтамж	эрг/мин	2925
6	Оврын хэмжээ: Урт	м	3960
	Өргөн		2000
	Өндөр		2000
7	Жин	кг	4700

Хүснэгт 19. DK40-4 маркийн зөөврийн сэнсний техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Өгөлт	м ³ /сек	10
2	Даралт	Па	2500
3	Статистик АҮК	%	68
4	Ажлын дугуйны диаметр	мм	630
5	Ажлын дугуйны эргэлтийн давтамж	мин ⁻¹	3000
6	Сэнсний масс	кг	420
7	Хүчдэл	В	380/220
8	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	25

Зураг 16-р зураг. DK40-4 маркийн зөөврийн сэнс



Ерөнхий агааржуулалтын сэнсий сонголт: Дээр тооцоонуудаас үзэхэд уурхайд шаардлагатай агаарын хэмжээ $55.0 \text{ м}^3/\text{сек}$, агаарын даралтын уналт 52.04 Па , эквивалент нүхний хэмжээ 1.46 м^2 зэргийг үндэслэн БНХАУ-д үйлдвэрлэсэн DK40-6 маркийн агааржуулалтын суурин сэнсийг ажиллуулахаар сонголоо.

Хүснэгт 20. DK40-6 маркийн суурин сэнсий техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Өгөлт	$\text{м}^3/\text{сек}$	55
2	Даралт	Па	325
3	Статистик АҮК	%	81
4	Ажлын дугуйны диаметр	мм	1100
5	Ажлын дугуйны эргэлтийн давтамж	мин^{-1}	1500
6	Сэнсий жин	кг	4560
7	Хүчдэл	В	380/660
8	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	80

Зураг 17. DK40-6 маркийн суурин сэнс



Хүснэгт 21. ЦНС-38-220 маркийн усны шахуургын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Бүтээл	м ³ /цаг	38
2	Түрлэг /напор/	м	220
3	Чадал	кВт	45
4	Овор хэмжээ /L×W×H/	мм	2330x273x796
5	Жин	кг	580

Зураг 18. ЦНС-38-220 маркийн усны шахуурга



Далд уурхайд өрөмдлөгийн ажил гүйцэтгэх үед хэрэглэгдсэн усыг мөргөцгөөс усыг соруулахад зөөврийн усны шахуургыг хэрэглэнэ.

2-р хүснэгт. DZD-25 маркийн усны шахуургын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
---	----------	-------------	-----------

1	Бүтээл	м ³ /цаг	5.7
2	Түрлэг	м	29
3	Чадал	кВт	1.5
4	Овор хэмжээ /L×W×H/	мм	400×250×200
5	Жин	кг	20

Хүснэгт 22. SD-300N маркийн утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүдэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Утгуурын багтаамж	м ³	3.0
2	Эргэлтийн радиус	м	5.9
3	Ачих хамгийн их өндөр	м	3.3
4	Явах ангийн урт	м	7.8
5	Явах ангийн өргөн	м	3.0
6	Их биеийн өндөр	м	3.5
7	Явах хамгийн их хурд	км/цаг	38.4
8	Хөдөлгүүрийн чадал	кВт	162
9	Жин	тн	16.5
10	Түлш зарцуулалт	л/цаг	25.0

Зураг 19. SD-300N маркийн утгуурт ачигч



Далд уурхайгаас олборлосон хүдрийг уурхайн амнаас баяжуулах үйлдвэр рүү, малталт нэвтрэлтээс гарах хоосон чулуулгийг хөрсний овоолго руу тээвэрлэх ажил зэрэгт 25 тн даацтай Nowo-336 маркийн автосамосвал хэрэглэнэ.

Хүснэгт 23. Howo-336 маркийн автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Хөдөлгүүрийн загвар	-	Cummins NT855
2	Хөдөлгүүрийн чадал	кВт (м.х)	186 (250)
3	Цилиндрийн тоо байрлал	-	Цуваа 6 (4 тактын)
4	Хамгийн их мушгих момент	Н*м	1200 эрг/мин
5	Ажлын эзлэхүүн	л	7.7
6	Түлшний савны багтаамж	л	300
7	Хүчний дамжуулгын төрөл	-	7DS180
8	Дугуй	-	14.00-R24
9	Өөрийн жин	кг	16000
10	Ачаалал хуваарилалт		
	Урд тэнхлэгт	кг	8000
	Хойд тэнхлэгт		12000
11	Даац, кг		25000
12	Оврын хэмжээ (урт, өргөн, өндөр)	мм	7365x2909x3145
13	Тэвшний геометр багтаамж	м ³	13.9
14	Дээд хурд	км/цаг	45
15	Түлш зарцуулалт	л/100км	18
16	Эргэх хамгийн бага радиус	м	9.5

Зураг 20. Howo-336 маркийн автосамосвал




1.8. Дэд бүтэц Цахилгаан хангамж

Далд уурхай ба ажилчдын тосгоны цахилгаан хэрэглэгчдийг одоогийн байдлаар Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас Бүдүүн-Ухаагийн уурхай хүртэл 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж 630 кВА хүчин чадалтай ТМ-630 маркийн трансформаторын дэд станцаас эрчим хүчээр хангадаг. Харин шинээр баригдах баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг найдвартай эх үүсвэрээс хангахын тулд Түмэнцогт сумаас 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татаж 1600 кВА хүчин чадалтай трансформаторын дэд станц байгуулан эрчим хүчээр хангана.


Зураг 21. Төвлөрсөн цахилгаан хангамжийн байдал



Зураг 22. Гадаад цахилгаан хангамжийн схем



Зураг 23. Уурхайн дотоод цахилгаан хангамжийн схем



Баяжуулалт: Уурхайгаас олборлосон хүдрээ гар аргаар ялгалт явуулна. 2026 онд 50.0 мян.тн хүдэр олборлон гар аргаар ялгалт хийж МБХЖ-92 маркийн 9.0 мян.тн баяжмал, МБХЖ-75 маркийн 12.5 мян.тн баяжмал, бага агуулгатай хүдэр 28.5 мян.тн-ыг ялган авна. Үлдэгдэл бага агуулгатай хүдрийг 2027 оноос флотацын баяжуулах үйлдвэр ашиглалтад

орохоор флотацын аргаар баяжуулна. 2026.01.01-ний байдлаар өмнөх онуудын үлдэгдэл 92 %-ийн агуулгатай МБХЖ-92 маркийн 8.4419 мян.тн баяжмал, 75 %-ийн агуулгатай МБХЖ-75 маркийн 6.70525 мян.тн баяжмалыг 2025 онд борлуулна.

Зураг 24. Бүтээгдэхүүний овоолго



Уурхайгаас олборлосон хүдрийг гар аргаар ялган баяжуулах ба баяжмалыг овоолго үүсгэн хурааж 7 хоног болгон ачилт хийлгэнэ. Энэхүү баяжмалын түр овоолго нь 1-2 м-ийн өндөртэй ойролцоогоор 100-150 м² талбайд байршина.

1.9. Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг нь хөдөлмөрийн явцад хүмүүсийн эрүүл мэндийг хэвээр хадгалах, хөдөлмөрийн чадварыг бууруулахгүй байх, аюулгүй ажиллах нөхцөлийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, техник тоног төхөөрөмж, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээний нэгдсэн систем юм. Хөдөлмөр хамгааллын бүх нэр томьёо, ойлголтыг стандартаар тодорхойлж өгнө.

Хөдөлмөрийн хуулинд заасны дагуу бүх үйлдвэр, албан газар, байгууллага, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг бий болгох үүрэгтэй. Ажилчид, албан хаагчдын аюулгүй ажиллагааны арга техник, үйлдвэрийн газрын ариун цэвэр, гал түймрийг эсэргүүцэх арга техникт зааварчлан сургаж, аюулгүй ажиллагааны арга техникийн шаардлагыг ажилчин бүр биелүүлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавихыг хөдөлмөрийн хуулийн дагуу үйлдвэрийн захиргаа хариуцна.

Үйлдвэрлэлийн явцад тоног төхөөрөмжийн үзүүлэх нөлөө

Үйлдвэрлэлийн явцад биеийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх тоног төхөөрөмжид бутлуур, чичиргээт шигшүүр, хуурай сепаратор, туузан дамжуулагч, тээврийн машин зэрэг орно.

Бутлах, шигших төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа:

Хацарт бутлуур, чичиргээт шигшүүрийн ажлын явцад их хэмжээний чимээ шуугиан үүснэ. Ийм учраас бутлалтын цехийг баяжуулах үйлдвэрийн барилгын тусгаарлагдсан хэсэгт байрлуулна. Тоосжилттой тэмцэхийн тулд тоос үүсэх хэсгүүдийг битүүмжлэн тусгаарлаж тоос сорогч системтэй холбох, нойтон цэвэрлэгээ хийх зэрэг арга хэмжээг авна.

Туузан конвейерийн аюулгүй ажиллагаа:

Туузан конвейерийн системд технологийн горимын дагуу том ширхэглэлтэй чулуу ба металл зүйлсийг цэвэрлэх төхөөрөмж, дагуу цууралт үүсэх, буцаж эргэх, хазгай гүйлт, халтиргаа үүсгэх, хэт их ачаалал, ховилоос мултрах, тууз тасрах зэрэг аваарын үед автоматаар зогсоох төхөөрөмж ба анхааруулах дохио суурилуулна.

Туузан конвейер байрлуулсан галерейн өндөр 2.0м-ээс доошгүй байвал зохино. Галерей дахь үйлчилгээний зайн нэг туузан конвейертай галерейд туузан конвейерийн нэг талд 0.7м нөгөө талд гол шугамын туузан конвейерт 0.7м бусад туузан конвейеруудад 0.4м-ээс доошгүй хэмжээтэйгээр тогтооно.

Туузан конвейерийн гинж шүдэт болон бусад дамжуулга, залгагч муфт залагч залагдагч бул, татах станцын ачаа, шижим зэрэг хөдөлгөөнт бие ангийг хааж хүн осолдохоос хамгаална. Хаалт хамгаалалтын бүтэц нь тосолгоо хийх, холхивчийн халалтыг шалгах ажиллагааг хаалт авахгүйгээр гүйцэтгэх боломжтойгоор байрлуулсан байна. Туузан конвейерийн залагч, залагдагч булыг битүү эсвэл торон хаалтаар хаана.

Үйлдвэрийн байр тасалгааны гэрэлтүүлэг:

Баяжуулах үйлдвэрийн цехүүд, ажлын байр болон дэвсгэр талбайг зөв гэрэлтүүлэх нь аюулгүй ажиллахад чухал ач холбогдолтой. Ажлын байр, шатны хонгил, гэрэлтүүлэг эрүүл ахуйн норм хэмжээнд хүрээгүйгээс осол аваар гарах эх сурвалж болдог учир ялангуяа шөнийн ээлжид гэрэлтүүлгийг норм хэмжээнд байлгах арга хэмжээг авч ажиллана. Үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн ба туслах байрны өрөө, тасалгааны гэрэлтүүлэг улсын стандартын шаардлага хангасан байна. Гэрэлтүүлэг нь байгалийн ба зохиомол хэлбэртэй байна.

Гэрэлтүүлэг нь ажлын байрны талбарт жигд тусгалттай, гялбалт үүсгэхгүй байх нөхцөлийг хангасан байх ба гэрэлтүүлгийн үүсгүүрийг тогтмол хугацаанд цэвэрлэж байна. Байгалийн гэрэл үүсгэгч нь нар бөгөөд гэрэлтүүлгийн хүч нь жилийн улирал агаар мандал дахь үүл, атмосферийн бохирдолт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг тул ажлын байранд байгалийн гэрэлтүүлгийн коэффициент 1.5 %-иас багагүй байлгана.

Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарах үед авах арга хэмжээ

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд автомат хяналтын систем суурилуулсан. Анхдагч хүдрийн туузан конвейерт PLC автомат хориглолын систем тохируулсан болохоор тоног төхөөрөмж осол аваар гарах үед автоматаар зогсоно.

Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд автомат унтраалга ашиглан эвдрэл гэмтэл гарсан үед хөдөлгүүрийг яаралтай зогсооно.

Баяжуулах үйлдвэрийн батлах дамжуулах төвлөрсөн хяналтын өрөө байршуулж, цехэд камер суурилуулан үйлдвэрлэлийн дамжлага явцыг хянана. Осол аваарын үед авах түргэн тусламж ба шуурхай арга хэмжээ. Үйлдвэрлэлийн явцад гарч болзошгүй осол аваар, хордлогын үед яаралтай түргэн тусламж авч хүмүүсийг түргэн хугацаанд нүүлгэн шилжүүлнэ.

Хөдөлмөр хамгааллын тусгай алба бүрдүүлж осол аваарын үед шуурхай тусламж үзүүлэх аргачлалыг буй болгох.

А.Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа: ХАБЭА-ын талаар дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлнэ. ХАБЭА-ын талаар мөрдөх журам боловсруулж хэрэгжүүлнэ. Үйлдвэрийн хэмжээнд технологийн бүх процессуудыг паспортжуулж хэрэгжилтийг хангана. ХАБЭА-ын ерөнхий зааварчилгаа, ажлын байр бүрийн холбогдол бүхий зааварчилгаагаар хангана. Галын аюултай тэмцэх бүх талын мэдлэг, дадлага эзэмшүүлэх, тухайн ажлын байрны зааварчилгаа гаргана. Шатах тослох материалын хадгалалт байршлыг мөрдөгдөж буй журмын дагуу хангана. Барилга объектууд галын аюулгүй байдлыг сахих нормативын дагуу байрлуулна. Цахилгаан станц (дизель) бусад хэрэглэгчдийн газардуулгыг зохих тооцооны үндсэн дээр хийнэ.

Хүдэр баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг үйлдвэрийн шинэ технологи, тоног төхөөрөмжтэй уялдуулан шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. Ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Мэргэжлээс шалтгаалах диспансертай гэрээ хийж, ажиллагсдыг улиралд нэг удаа

эрүүл мэндийн үзлэгт оруулна. Ажиллагсдын хөдөлмөрийн чадварыг хэвийн хадгалахын тулд амралтын ВАХТ–н системийг нэвтрүүлнэ. ХАБЭА сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулна. Ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр хийх ажлын тусгай төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ. Химийн бодисыг зохих хууль дүрмийн дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглана. Шатах, тослох материалын агуулахыг зөв оновчтой газар байршуулж галын аюулгүй байдлыг хангана. Үйлдвэрийн барилгын зарим хэсгүүдэд аюулгүй ажиллагаа, ариун цэвэр эрүүл ахуйн стандартын шаардлагуудыг хангана. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөс хамгаалах урьдчилан сэргийлэхийн тулд ажилчдыг хувцас хамгаалах хэрэгслээр хангана.

Б. Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал: Хөдөлмөрийн явцад хүмүүсийн эрүүл мэндийг хэвээр хадгалах, хөдөлмөрийн чадварыг бууруулахгүй байх, аюулгүй ажиллах нөхцөлийг хангахад чиглэсэн хууль тогтоомж, техник тоног төхөөрөмж ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээний нэгдсэн систем юм.

Хөдөлмөр хамгааллын бүх нэр томъёог стандартаар тодорхойлж өгдөг. Аюулгүй ажиллагаа гэдэг нь үйлдвэрийн аюулгүй ба хортой хүчин зүйлүүд нөлөөлөхөөргүй хөдөлмөрийн нөхцөл юм. Үйлдвэрийн аюултай хүчин зүйлүүд ажилтны эрүүл мэндэд нөлөөлснөөр гэмтэл учруулах буюу эрүүл мэнд гэнэт муудахад хүргэнэ. Хортой хүчин зүйлүүдэд ажилтны эрүүл мэндэд муугаар нөлөөлөх бүх хүчин зүйлс багтана. Баяжуулах үйлдвэрт ажилд орж байгаа ажилтан албан хаагч бүр эмнэлгийн урьдчилсан үзлэг хийлгэсэн байх шаардлагатай. Мөн ажиллагсад тогтоосон хугацааны дотор эмнэлгийн үзлэгт орж байх ёстой. Ажилд шинээр орж буй ажилчид урьд нь баяжуулах фабрикт ажиллаж байсан эсвэл дотроо нэг мэргэжлээс нөгөө мэргэжлийн ажилд шилжиж буй бол ажилчид тогтоосон программын дагуу үйлдвэрлэлд ажиллуулахаас хоёр хоногийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааны сургалтад хамрагдаж үйлдвэрийн ерөнхий инженер буюу түүний орлогчоор удирдуулсан комисст шалгалт өгнө.

Ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техник, үйлдвэрлэлийн эрүүл ахуй болон галын аюулгүйн дүрэм, норм зааврын шаардлагыг чанд мөрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнүүдээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтад хамрагдсан байх ёстой.

Соронзон ялгагч ажиллаж байхад соронзон систем руу соронзон шинж чанар бүхий эд зүйлийг ойртуулахыг хориглоно. Цахилгаан соронзон ялгагчийг зогсоохдоо соронзон системийн ороомгоос хүчдэлийг заавал салгана. Хүдрийг хуурайгаар соронзон ба цахилгаан соронзонгоор баяжуулах үед уг соронзон ялгагч нь тоос барих системтэй хоолойгоор холбогдсон битүү

бүрхүүлтэй байна. Тоос цуглуулах систем ажиллаагүй буюу гэмтэлтэй үед ялгагчийг ажиллуулахыг хориглоно.

Ялгагч ажиллаж байхад түүний ажиллагаа, ховилын байдлыг хянах, сэтгэх нээлхийнүүд хаалттай байна. Тэжээгчийн ховилоос гараараа зомгол, элдэв зүйлс авахыг хориглоно. Ялгагчийг туузын байрлал, материал татах зай түүний доор янз бүрийн юм хавчуулж тохируулахыг хориглоно.

В. Галын аюулгүй ажиллагаа: Баяжуулах үйлдвэрийг барих буюу тоноглохдоо амархан галд автах ба шатамхай бодис агуулсан цехүүдийг барилгын норм ба дүрмийн галын аюулгүй ангиллыг баримтална. Үйлдвэрлэлийн байр байгууламж, гал эсэргүүцэх тоног төхөөрөмжүүд нь “Үйлдвэрийн газрын галын аюулаас урьдчилан сэргийлэх үлгэрчилсэн дүрэм”-ийг баримталсан байна. Үйлдвэр нь өөрийн хийгээд ойр орчны сууринуудын гал командтай телефон харилцаатай байна.

Д. Үйлдвэрийн дуу шуугиан. доргион: Шуугиан түүнтэй тэмцэх өндөр, нам, чанга, сул, үелзэл, хүчээрээ адилгүй хослолыг шуугиан гэх ба хүчтэй шуугиан нь хүний сонсголын эрхтэн, мэдрэлийн системд нөлөөлж анхаарал сулруулах буюу дуут дохиог хүлээн авахад хүндрэл учруулах зэргээр бие организмд физиологийн болон сэтгэл санааны үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг. Шуугианыг дараах аргаар бууруулна.

- Үүсгэгчийн шуугианыг бууруулах
- Дуу шингээх ба тусгаарлах хэрэгсэл ашиглан шуугианы тархалтыг хязгаарлах.

Дуу шуугиан нь ажиллагсдын бие махбодод шууд ба шууд бусаар нөлөөлнө. Доргион нь хүний мэдрэл, зүрх, судасны систем, тулгуур, хөдөлгөөний цогцост хортойгоор нөлөөлнө.

Доргионоос урьдчилан сэргийлэхдээ:

Доргион хэмжээс зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн агрегаттай ажлын байранд доргионыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах зөөллүүр тавьж өгнө. Хурдан эргэлттэй машины эргэлдэгч хэсгүүдийг маш нарийн тохируулах.

Барилгын хийц хэсгүүд (багана, тулгуур г.м) –ийг машины суурьтай холбож болохгүй.

Ё. Үйлдвэрийн эрүүл ахуй: Ажилд шинээр орж байгаа хүмүүс нь эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт орж магадлагаа гаргуулсан байна. Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу эмнэлгийн салбар байгуулан эмч, сувилагчийг орон тоогоор батлан ажиллуулж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

Ажиллагсад эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцас хамгаалах хэрэгслээр хангаж, хэрэглээнд нь хяналт тавина. Ажлын байрнаас 300 м-с ихгүй зайд хувцас солих, эд зүйлс тавих,

толь, хогийн сав зэрэг ахуйн хэрэгцээтэй тоног хэрэгслээр тоноглогдсон цэвэр агаараар байнга сэлгэгдэж байх ахуйн байраар хангана.

Далд уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Босоо малталтаар ачаа болон хүн тээвэрлэх аюулгүй ажиллагаа: Босоо гол амаар ажилтан оруулах, гаргах ажлыг клетээр гүйцэтгэнэ. Босоо малталтыг нэвтрэх үед ажилтнуудыг оруулж гаргахдаа хөнөгөөр зөөвөрлөж болно. Ажилтан оруулах ба гаргахад зориулсан клеть нь ган татлага тасрах тохиолдолд зөөлөн тоормосолж тогтооход зориулсан хэрэгсэл байна. Босоо гол амны дохиочин ба машинч нь ойлгомжгүй дохио бүрийг "ЗОГС" гэсэн дохиотой адилтган үзэх ёстой. Ойлгомжгүй дохионы шалтгааныг машинч нь телефон утсаар буюу шууд харилцах утсаар биечлэн ярьж тодруулсны дараа ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Өргөх төхөөрөмж бүрийг босоо гол амны дохиочноос дээд дохиочинд дээд дохиочноос машинчид дохио өгөх хэрэгслээр тоноглох тэрчлэн босоо гол амны үзлэгийн үед хэрэглэх завсрын дохиотой байна.

Галын аюулгүй ажиллагаа: Далд уурхайд утаа мэдрэгдэх, ил гал гаргах, шатамхай материал уурших, ноцох түүнчлэн уурхайн агаарын найрлага дахь нүүрстөрөгчийн хийн агуулга өөрчлөгдөх, зөвшөөрөгдсөн хэмжээнээс давах үзэгдлийг далд уурхайн гал түймэр гэж үздэг. Далд уурхайд цахилгааны дотоод сүлжээнээс хамаарч гал түймэр гарах магадлал өндөр байдаг. Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг ажиллагсад ашиглуулж сургах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гурван шатны үзлэг, сургалтад хамруулах шаардлагатай. Үүнд:

1. Ээлж, бригадад
2. Байгууллагын доторх нэгж, хэсгүүдэд
3. Байгууллагыг бүхэлд нь

Галын аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн тодорхой нөхцөлд баталгаажуулж эсвэл журмын дагуу үйлдвэрлээгүй шинэ бодис, материалыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцэд хэрэглэхийг хориглоно. Далд уурхай ба үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаагаа алдах үед анхааруулах дохио өгөх, аваар гарах, аюулд хүргэж болзошгүй горимоор ажиллах тохиолдолд автоматаар унтрах, хөдөлгүүр болон цахилгааны эх үүсвэрээс салгагдах хэрэгсэлтэй байна. Тоног төхөөрөмжийн ажил гүйцэтгэх хэсэг, эд

ангиуд нь тэдгээрийг ажиллуулах эрчим хүчний эх үүсвэр /цахилгаан гүйдэл, шахагдсан хий гэх мэт/ тасарснаас үүсэх аюул ослоос урьдчилан хамгаалах, эрчим хүчний эх үүсвэрийг дахин залгах үед өөрөө залгагдахгүй хэрэгслээр хангагдсан байхаар тоноглогдсон байна.

Далд уурхай тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд тавих шаардлага үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Уурхайн үйл ажиллагаанд хэрэглэгдэх машин механизм, техник тоног төхөөрөмжүүд нь ажлын байр хүрээлэн байгаа орчныг бохирдуулахгүй байхын зэрэгцээгээр ХАБЭА-н шаардлага хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжүүд нь далд уурхайн технологийн горимд нийцсэн байх
- Техник, тоног төхөөрөмж нь тус бүрдээ ашиглалтын заавар, паспорттай байх
- Техник, тоног төхөөрөмжийн хяналт хэмжилтийн багажууд нь улсын стандарт хэмжил зүйн албаар заавал баталгаажуулагдсан байх
- Техник, тоног төхөөрөмж нь аливаа засвар үйлчилгээ хийхэд тохиромжтой байрлал нөхцөлөөр хангагдсан байх

Далд уурхайд ажиллаж байгаа техник тоног төхөөрөмжийн тасралтгүй болон осол авааргүй байдлыг хангаж байх зориулалттай дохиоллын систем ажиллаж байхын зэрэгцээ аюул ослоос хүмүүсийг урьдчилан сэргийлэх дохио өгөх зориулалттай дохиоллыг бас тоноглож өгнө.

- Машин механизмыг асаах /ажиллуулж эхлэх/ тухай дохиолол
- Ачаатай тэргэнцэр хөдөлж эхлэхийг анхааруулсан уурхайн тээврийн дохиолол
- Хүмүүст аюул учруулж болох тохиолдол үүсэх үед өгөх аваарын дохиолол

Далд уурхайд нэгдсэн журмаар заах, урьдчилан сэргийлэх, хориглох тэмдгүүдийг байрлуулна. Малталт нэвтрэх үед тохиолдож болох ослын гарч болзошгүй шалтгаанууд:

- Хана, таазнаас чулуу унах, нуранги үүсэх
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгслээс гэмтэх
- Тэсэлгээний ажлын дүрэм журмыг зөрчих
- Тэсэлгээний дараагаар үүсэх хорт хийнээс хордох
- Хувийн гэрэл болон хамгаалах хэрэгсэлгүй ажиллах
- Мөргөцөгт шпур өрөмдөх өрөмдлөгийн ажлыг хуурай өрөмдөх

Нурлаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй холбоотой ослоос сэргийлэх

- Малталтын хөндлөн огтлолын талбайн хэмжээ, малталт болон бэхэлгээний хэлбэр зэргийг чулуулгийн физик механик шинж чанартай нь уялдуулан тооцож сонгох
- Малталтын хана, таазнаас нурахад бэлэн болсон хөмсөгүүдийг хусаж цэвэрлэх

Тэсрэх материал тээвэрлэх, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагаа

Тэсрэх материал хэрэгслийг тээвэрлэх

Гадаад тээвэр: Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг зөвхөн тусгайлан тоногдсон автомашинаар тээвэрлэх ба замын хөдөлгөөний дүрмийг чанд баримтална. Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхдээ тэсэлгээний эрхийн үнэмлэхтэй ажилтан, эсвэл тэсрэх материалтай харьцаж ажиллах эрх бүхий тэсрэх материалын агуулахын эрхлэгч, түгээгч болон бусад эрх бүхий ажилтан биечлэн хариуцах бөгөөд хамгаалалтын хүмүүс дагалдан явна. Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг авто тээврээр тээвэрлэхдээ замын маршрут, ачилт хийх замд явах буулгах тодорхой хугацаа бүхий зөвшөөрлийг техникийн бэлэн байдлаас харгалзан үзэж мэргэжлийн хяналтын ерөнхий газар, цагдаагийн байгууллагад бүртгүүлнэ. Тэсрэх материалыг уурхайн дэргэд байрлах түр агуулахад буулгаж тухайн орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

Дотоод тээвэр: Тэсрэх материалын төв агуулахаас уурхайн их ам хүртэл тусгай тоногдсон автомашинаар тээвэрлэнэ. Уурхайн их амнаас цааш тэргэнцэр болон бусад далд уурхайн тээврийн хэрэгслээр тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцүүлэн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж тээвэрлэнэ. Уурхайн их амаар ажилчид орж гарч байх үед тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхийг хатуу хориглоно. Тэсрэх материалыг уурхайн их амаар ачиж, буулгах, зөөвөрлөх үед уурхайн их амны ойролцоох малталт их амны дээр байгаа байгууламжид зөвхөн тэсэлгээчин, дохиочин, тэсэлгээний материалыг ачиж буулгах ажилчин түүнийг хүргэх ажлыг хариуцсан ажилтан байна.

Тэсрэх бодистой хайрцаг, сав нь уурхайн өргөх машины /клеть/ өндрийн гуравны хоёр буюу клетний хаалга болон тэргэнцрийн хашлагаас тус тус өндөргүй байна. Тэсэлгээний хэрэгслийг тэсрэх бодисоос тусад нь тээвэрлэнэ. Далд уурхайд тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхдээ дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг ачих буулгах ажлыг зөвхөн зориулалтын газарт явуулна,
- Ослын нөхцөлд ачих, буулгах талбайг хяналтын ажилтан, тэсрэх материалтай харьцах хариуцагч нар тогтооно,

- Нэг цуваанд тэсрэх бодис, өдөөгч хэрэгслийг тээвэрлэхдээ тэдгээрийг өөр өөр тэргэнцэрт ачих. Тэсрэх бодистой тэргэнцэр болон цуваанд өөр төрлийн ачаа ачихгүй
- Тэслүүрийг битүү тагтай, модон материалаар доторлосон тэргэнцэрт ачих, өдөөгч хэрэгсэлтэй цүнх савыг зөөлөн материалаар бүрж нэг эгнээгээр өрсөн байх, бусад тэсрэх материалыг ердийн тэргэнцэрт хашлага хүртэл ачиж тээвэрлэнэ,
- Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж байгаа тэргэнцрийг урд хойд талд тусгай гэрлэн тэмдэг тавьсан байна,
- Уурхайд тэсрэх материал тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн өмнөөс ирж байгаа тээврийн хэрэгсэл болон зогсож өнгөрүүлнэ,
- Тэсрэх материалыг тээвэрлэж байгаа ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч гарын үсэг зуруулсан байна,
- Тэсрэх материалыг тээвэрлэж байгаа хариуцагч нараас өөр хүн байхыг хатуу хориглоно.

Тэсэлгээний ажлын үед баримтлах аюулгүй ажиллагаа:

Далд уурхайд хийгдэх тэсэлгээ бүрт тусгай төсөл боловсруулж мөрдлөг болгоно. Тэсэлгээний ажлын дүрэм, тухайн уурхайд мөрддөг журмын заалтуудыг хатуу баримталж тэсэлгээний ажлыг зохион байгуулна. Тэсэлгээний ажлын зохион байгуулалтыг дараах ерөнхий дараалал байдлаар ойлгож болно. Үүнд:

- Тэсэлгээний төсөл зохиож батлуулах
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зарцуулах зөвшөөрөл авах
- Тэсэлгээний материалыг агуулахаас зөөж тэсэлгээний блок, мөргөцгүүдэд хүргэх
- Шпур цэнэглэх ба түгжээс хийх
- Тэсрэлтийн аюултай бүсээс хүмүүс болон тоног төхөөрөмжийг гаргах
- Тэсрэлтийн аюултай бүсэд буй цахилгааны шугамд салгалт хийх
- Тэсэлгээний схемийн холболтуудыг хийж тэсэлгээнд бэлтгэх
- Тэсэлгээний схемийн бэлэн байдлыг шалгах
- Тэсэлгээ явуулах тухай дохио өгөх
- Тэсэлгээг хийх
- Тэсэлгээний дараах агааржуулалт хийх

- Тэсэлгээний хяналтын үзлэг хийх ба тэсэлгээ хэвийн явагдсан бол тэсэлгээний ажил дууссан тухай дохио өгөх. Хэрэв зарим цооногийн цэнэгүүд баарч тэсрээгүй бол тэдгээрийг тэсэлж аюулгүй болгох арга хэмжээ авах ба дараа нь тэсэлгээний ажил дууссан тухай дохио өгөх
- Тэсэлгээний дараа сэргээлтийн ажлуудыг хэрэгжүүлэх
- Цахилгааны шугамуудыг шалгаж холболт хийх ба ачигч машин зэрэг төхөөрөмжүүдийг мөргөцгүүдэд байршуулж ажилд бэлдэх. Зам тээврийн холбогдолтой малгалтуудын сэргээлтийн ажлуудыг хийх
- Тэслэгдсэн чулуулгийн холбогдолтой хяналтын хэмжилт, тооцоог хийж дүгнэлт гарган тухайн тэсэлгээний ажлыг дуусгасан тухай баримт бичгийг бүрдүүлэх

Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ

Агаар хамгаалах чиглэлээр: Агаарын чанарт дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

- Машин механизмаас гарах утаа, хий
- Зам барилгын үед гарах тоос
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоос зэргээс агаарын чанар хамаарна.
- Орчны агаар бохирдуулах эх үүсвэр нь хүдэр ангилан ялгах технологийн дамжлагын бутлах төхөөрөмжүүд юм.

Агаар дахь химийн бодисын агууламж стандартад заасан хүлцэх агууламжаас хэтэрч байвал агаар орчин бохирдсонд тооцдог.

Иймд цаашид дотооддоо агаарын мониторингийн багажтай болж хяналтыг тогтмолжуулах тоосонцрын хэмжээг тогтоох шаардлагатай.

Хөрс хамгаалах чиглэлээр: Орд орчмын нутгийн байгаль орчныг хамгаалах, олборлолт явуулж буй газартай байгалийн унаган төрөхийг аль болох хэвээр хадгалах үүднээс уурхайн болон тосгон суурины эзэмшлийн газрын дотоод замын сүлжээг тогтоож эвдэгдсэн газруудыг буцаан ургамалжуулах хэрэгтэй.

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр:

- Үйл ажиллагааны явцад ашиглагдаж дахин зөөгдөхгүй дарагдахгүй талбайд нөхөн сэргээлт хийх, ургамалжуулах
- Хүнд машин механизмыг зөвхөн маршрутын замаар явуулах

- Автомашины зам, зогсоолын талбайг тэмдэгжүүлэх, замын сүлжээг оновчтой зохион байгуулах
- Ойр орчиндоо ургах ургамлын төрөл зүйлд хяналт тавьж, бүртгэх ажиглалт явуулах
- Машин механизмын засвар үйлчилгээ хийх үед санамсаргүй тохиолдлоор шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж засварын цех байрлах талбайг хатуу хучилттай болгох зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллах зүйтэй юм.

Усан орчныг хамгаалах чиглэлээр: Одоогоор үйлдвэрлэлийн улмаас газрын доорх болон гадаргын усанд нөлөөлөх нөлөөлөл үгүй байгаа ч хойшид анхаарч ажиллах зүйлс:

- Усны хэрэглээнд хяналт тавьж ажиллах
- Үүсэж болзошгүй үерийн урсцыг тодорхойлж, далан хаалтыг хийх
- Олборлолтын явцад шатах тослох материалыг зохих журмын дагуу хадгалж, улмаас хөрсөнд алдагдсан тохиолдолд шуурхай цэвэршүүлэх арга хэмжээ авч эрсдэлээс гарах төсөл төлөвлөгөө боловсруулан ажиллах

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт хаалтын төлөвлөлт

Уурхайн байгаль орчны удирдлагын тогтолцоо нь уурхайн дэргэдэх удирдлагын нэгж хэсэг болно. Үүнд уурхайн Байгаль орчныг хамгаалах нэгж болох Байгаль орчны мэргэжилтэн 1 хүн ажиллана. Үүнд:

Байгаль орчны мэргэжилтний үндсэн чиг үүрэг нь байгаль орчны төлөвлөлт, хяналт тайлангийн гүйцэтгэлийг жил сар бүрээр гаргаж үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ. Ингэхдээ өдөр тутмын үйл ажиллагааг өөрийн нэгжийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг хянах тайлагнах, шаардлагатай үед биечлэн зөвлөгөөг өгөх замаар шуурхай удирдлагаар хангана. Бүдүүн-Ухаагийн хайлуур жоншны орд нь далд уурхайн аргаар ашиглалтын үйл ажиллагаа явуулах тул шинээр эвдрэлд орох талбай гарахгүй.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт: 2024 онд уурхай "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 ш мод тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт тарихаар төлөвлөж байна.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийх талбайг орон нутагтай хамтран ажиллах гэрээг хийсний дараагаар орон нутгаас заасан газарт хийх тул солбицлын мэдээллийг 10-р маягтад тусгах боломжгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 24. Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй

№	Байгаль орчны бүрдэл	Товч тайлбар
1	Физик газарзүйн нөхцөл	“Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл” нь физик газарзүйн мужлалын хувьд Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын дундад ухаа гүвээт талд оршиж байна. Экосистемийн доройтлын хувьд багаас дунд зэрэг доройтсон бүсэд хамаарна. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр нь усан сүлжээний хувьд тогтмол урсацтай гол горхи байдаггүй. Төслийн талбайгаас баруун урд зүгт 6 км зайд Баяндалай нэртэй 1 булаг, түүгээр тэжээгддэг улирлын горим бүхий Баяндалай нуур нэртэй давст тойром байна. Нутаг дэвсгэрийн хэмжээнд томоохон хөндийнүүдэд (хотгорт) хуурай тойрмууд оршино. Тойрмууд нь хур тунадас ихтэй жил дүүрдэг. БүДҮҮн—Ухаа жоншны ордын тусгай зөвшөөрлийн талбай нь 11301185 м өргөгдсөн байх бөгөөд ойролцоо орших хамгийн өндөр цэг нь төслийн талбайгаас баруун зүгт 7 км-т байрлах 1369.3 м өндөртэй “Баян уул” нэртэй уул болно. Төслийн талбайн баруун, баруун хойд талаар нам уулс жижиг толгод хүрээлэх ба зүүн талаар нь Баянхааны хоолой хүрээлж байна.
2	Цаг уур уур амьсгал	Төсөл хэрэгжих бүс нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай халуун, хуурай бүсэд хамаарагдах бөгөөд хоногийн болон жилийн температурын зөрөө эрс өөрчлөлт ихтэй ба жилийн дундаж хэм нь -20С. Хамгийн хүйтэн үе нь 12-р сараас 2 сарын эхэн байдаг ба -28.50С-ээс -32.90С хүртэл хүйтэрдэг бөгөөд хамгийн халуун сар нь 7-8-р сар, +23.0С-ээс +33.0С-ийн дулаантай байдаг. Жилийн хур тунадасны хэмжээ 101-343мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр буудаг. Өвөлд 10-20мм-ээс хэтрэхгүй цас ордог, цасан бүрхэвчийн зузаан 5-8см боловч зарим жилийн өвөлд цас ороогүй тохиолдол цөөнгүй тохиолддог. Анхны цас 10-11 сарын үед ордог ба 3-р сард хайлж дуусдаг. Агаарын чийгшилт зундаа 46-68%, харин өвөлдөө 60-85%-д хэлбэлздэг. Өвөлдөө хүйтэн боловч хур тунадасгүй нарлаг цаг агаар зонхилдог, хавартаа ч мөн адил боловч салхи шуурга ихтэй байдаг. Хүйтний улиралд хөрсний хөлдөлт гадаргуугаас дунджаар 2-2.5м, олон жилийн цэвдэг байхгүй. Хавар цагт бараг тогтмол салхи шуургатай байдаг ба салхины хурд дунджаар 4.7м/сек гэх боловч зарим үед 14-18м/сек, үе үе 20-24м/сек хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг. Салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байдаг.

3	Агаарын чанар	Төсөл хэрэгжиж байгаа талбайд ОХШХ-ийн дагуу 2022 онд Сүхбаатар аймгийн “Ус, Цаг уур, Орчны шинжилгээний газар”-тай хийсэн гэрээний дагуу 3 цэгт агаар чанарын хэмжилтийг хийлгэсэн. Тухайн хэмжилт хийсэн талбайд хүхэрлэг хийн хэмжээ дунджаар 0.01 мг/м ³ , азотын давхар ислийн хэмжээ дунджаар 0.024 мг/м ³ агууламжтай байсан бол нийт тоос хамгийн их утгаар 0.25 мг/м ³ агууламжтай гарсан бөгөөд MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.
4	Гадаргын болон газрын доорх ус	Төслийн талбайгаас баруун урд зүгт 6 км зайд Баяндалай нэртэй 1 булаг, түүгээр тэжээгддэг улирлын горим бүхий Баяндалай нуур нэртэй давст тойром байна. Нутаг дэвсгэрийн хэмжээнд томоохон хөндийнүүдэд /хотгорт/ хуурай тойрмууд оршино. Тойрмууд нь хур тунадас ихтэй жил дүүрдэг.
		Бид 2022 онд уурхайн 1 болон 2-р ам ундны усанд хийсэн шинжилгээний дүнгүүдийг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900:2005”, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:1998”, “Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010” стандартуудтай харьцуулахад, стандарт хэмжээг давсан үзүүлэлт ажиглагдаагүй байна.
5	Хөрсөн бүрхэвч	Уурхайн талбай нь говь хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Үржил шимт хөрсний давхарга сул хөгжсөн ба дунджаар хөрсний зузаан нь 5-12см байна. Нам дор газартаа 8-16см байх ба тэгш өндөрлөг газруудад хар хүрэн, хар саарал хөрс зонхилж, мараалаг борзон хайрга, чулуун хуягаар зарим газраар бүрхэгдэнэ. Хонхор, хотгор газруудаар хужир тойром мараалаг хөрс элбэг тархсан байдаг. Хөрсний хүнд металлын шинжилгээгээр Хромын агуулга илрээгүй, Хар тугалга 25.8-26.7 мг/кг буюу ЗДХ-ээс 73.3-74.2 мг/кг аар бага, Кадми уурхайн зүүн амын дэргэдээс авсан дээжид 0.5 мг/кг, урд амны дэргэдээс авсан дээжид илрээгүй, Мөнгөн ус уурхайн зүүн амын дэргэдээс авсан дээжид 0.3 мг/кг, урд амны дэргэдээс авсан дээжид илрээгүй, Цайр 133.8-170.6 мг/кг буюу ЗДХ-ээс 2 дахин бага агууламжтай буюу бохирдолгүй байна. Мөн 2022 оны ОХШХ-ийн дагуу хийсэн хөрсөнд агуулагдах хүнд металлын лабораторийн шинжилгээний дүнгээр MNS 4585:2016 стандартад заасан хэмжээг даваагүй байна.
5	Амьтны аймаг	Энэ дүүрэгт ан амьтад нэлээд элбэг бөгөөд махчин амьтдаас үнэг, хярс дорго, мануул, чоно зэрэг амьтад багагүй тааралдана. Туурайтан амьтдаас цагаан зээр бөгөөд намартаа нүүдэллэн ирдэг. Жигүүртэн амьтдаас сар, элээ, хэрээ, харцага, тогоруу, ногтруу, шаазгай, хулан жороо, шар шувуу, өвөөлж, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчин амьтдаас шар сүүлт, алаг даага, тарвага, зурам, оготно, шавж идэштнээс зараа зэрэг амьтад элбэг тохиолдоно. Хөхтөн амьтад: Мөнххаан сумын нутагт 6 багийн 11 овог 24 төрөл 28 зүйл хөхтөн амьтан нутаглаж байна. Мөнххаан сумын нийт болон Бүдүүн-Ухаагийн уурхай орчимд 8 баг, 11 овог, 26 төрөлд хамаарагдах 34 зүйл шувуу идэштэн нутаглаж байна. Шувуудын зүйлийн бүрэлдэхүүнийг хүснэгт 6.10-т харуулав. Энэ нутагт

		тархсан 34 зүйл шувуудын 85% жилийн аль ч улиралд тэндээ суурин нутагладаг, 15% нь нүүдлийн шувууд байна. Эдгээр шувуудаас агнуурын ач холбогдолтой нүүдлийн ангир, анхидал, суурин хадны тагтаа, хөх бор тагтаа, дагуур ятуу гэх 5 зүйл жигүүртэн энэ нутагт бий. Харин шилийн сар, идлэг шонхор, шууман шонхор, зээрд шонхор,сохор элээ, тарвага, шар шувуу, хотны бүгээхэй зэрэг 8 зүйл шувуу байна.
6	Ургамлын аймаг	Төсөл хэрэгжих бүс нутаг нь ургамлын мужлалын хувьд говь хээрийн мужийн монгол өвст-бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана бударгана зэрэг бутлаг ургамал тааралдах ба монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал зонхилон ургадаг. Бүс нутгийн хувьд өвс ургамал нь ерөнхийдөө жигд боловч тачирхан байдаг ба нутгийн зүүн хагаст өвс ургамал нь нэлээд өтгөн шигүү ургаж тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн мал аж ахуйд ихээхэн ач холбогдолтой байна. Сүүлийн хэдэн жилүүдэд хур тунадас бага орж, зуны цагт хуурайшин халснаас болж өвс ургамлын гарц жил ирэх тутам муудаж байна.
7	Тусгай хамгаалалттай газар нутаг	“Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн талбайгаас зүүн хойд зүгт 12-15 км зайд “Баянцагааны тал” нэртэй улсын тусгай хамгаалалттай газар нутаг (УТХГН) оршиж байна. Тус “Баянцагааны тал” нь УТХГН-ын ангиллаар “Байгалийн нөөц газар” гэж тодорхойлогдсон байна. “Хунт-Өгөөж” ХХК-ийн “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн ашигт малтмал ашиглах “MV-016689” дугаартай тусгай зөвшөөрлийн талбай нь “Наран-Сарангийн тал” нэртэй Сүхбаатар аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн дотор оршиж байна.
8	Нийгэм эдийн засаг	Мөнххаан сум нь 710 км.кв нутаг дэвсгэртэй, засаг захиргааны 5 багтай, 2018 оны жилийн эцсийн мэдээгээр 4828 хүн амтай, 457.6 мянга гаруй толгой малтай томоохон сум байна. Сумын төв нь Баясгалант баг болно.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ

ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотгол ажлын хүрээнд “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээг дараах байдлаар ангилан тодорхойлов. Үүнд:

1. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ;
2. Гол сөрөг нөлөөллийн үнэлгээ.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Дэд бүтцийн байгууламжуудыг барих;
2. Далд уурхайн нэвтрэлтүүд;
3. Далд уурхайн олборлолтын үйл явц;
4. Хүдрийг бутлан ангилах, баяжуулах үйлдвэр;
5. Өрөмдлөг тэсэлгээний ажил, тэсрэх материалын агуулах;
6. Хуучин ил уурхай ба овоолгууд;
7. Уурхайн ашиглалтын зам ба талбай;
8. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам ба тээвэрлэх үйл явц;
9. Ажилчдын хотхон ба ашиглалтын үйл ажиллагаа;
10. Хатуу ба шингэн хог хаягдлын цэг, талбай.

Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Ил ба далд уурхайн малталтын үед аюулгүй ажиллагаа дүрэм зөрчигдөх, технологийн буруу ажиллагаанаас үүдэн хөрсний нуралт, гулгалт зэрэг осол аваар үүсэж болзошгүй
- Уурхайн захиргаанаас бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрутыг тогтоон баталж тэмдэгжүүлээгүй, баталсан маршрутаар хийгээгүйн улмаас олон салаа зам үүсэж болзошгүй
- Төслийн үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлдвэрлэлийн (тэсэлгээний ба бусад) болон ахуйн зориулалттай химийн бодисууд ямар нэгэн байдлаар асгарснаар газрын хэвлий болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй;
- Уурхайн дотоод ба гадаад тээвэрлэлтийн үед их хэмжээний тоос дэгдэж ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсэж газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Уурхайн хатуу хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.

Агаар орчин:

Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй;

Амьтны аймаг:

Шөнийн цагаар уурхайн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;

Уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам нь үйл ажиллагаанаас амьтадын аймаг, тэдгээрийн амьдралын зүй тогтолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй

Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

Хүний эрүүл мэнд:

Уурхайн бүхий л үйл ажиллагаа нь “Ил болон далд уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад дүрэм зааврын дагуу явагдах ёстой. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учирч болзошгүй;

Гол сөрөг нөлөөлөл

Хөрсний дээд хэсгийн ялзмагт давхарга нь ургамлыг шим тэжээлийн бодисоор хангах гол эх үүсвэр болохоос гадна бохирдлын бодисуудыг саармагжуулах үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эвдрэлд орсон тохиолдолд газар дээрх хог хаягдлын хортой бодисууд нь гүний болон гадаргын усыг бохирдуулах нөхцөл бүрдэнэ. Уурхайн уул ажиллагаанд өртсөн газар нь эвдрэл доройтолд орсон байна.

Хүснэгт 25. Хөрсний эвдрэлийн байдал талбайн хэмжээнд

№	Эвдэрсэн газар	Талбай,га		Нийт талбай, га
		Талбай дотор	Талбайн гадна	
1	Эвдэрсэн хөрс	24.30	0.5	24.8

Уурхайн уулын ажлын төлөвлөгөөнд зарим эвдрэлд орсон хөрсний талбайг оруулаагүй байсан тул агаар сансрын сүүлийн үеийн зураг ашигласан болно. Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орсон болон орох хөрсний талбайн хэмжээг тооцоолоход 24.8 га (Талбай дотор 24.3 га талбайтай хөрс эвдэрсэн) гарч байна. Тус талбайгаас гадна 0.5 га талбай уурхайн үйл ажиллагаа болон холбоотой үйл ажиллагаагаар эвдрэл доройтолд орсон байна.

Хөрсний бохирдолт

Газрын хөрс нь агаар, ус, цас, ургамлыг бодвол хөдөлгөөн багатай, нэг байрандаа урт удаан хугацаагаар оршин байдаг байгалийн тогтвортой систем учраас техногений нөлөөллийн бүх хугацааны туршид ялгарч гарсан бохирдуулагч бодисуудыг өөртөө шингээж удаан хугацаагаар хадгалах чадвартайгаараа онцлог юм. Энэ учраас хөрсний бохирдлын судалгаа нь хот суурин газрын экологийн үнэлгээний салшгүй үндсэн хэсэг нь болдог аж.

Хүний үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус гэх мэтийн үүсвэрүүд багтдаг.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Хунт-Өгөөж” ХХК-ийн “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг ашиглах” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс уурхайн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн болон БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан, тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө зэргийг үндэс болгон боловсруулсан.

БҮЛЭГ 5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Хүснэгт 26. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Агаарын чанар									
1	Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг засварлах	Уурхайн тээврийн зам	-	-	-	2000.0	Хуурайшилттай үеүдэд 7 хоногт 1-2 удаа	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008 MNS3384:1982 “Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ”
2	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Төслийн хүрээнд	-	-	-	500.0	Үйл ажиллагааны туршид	MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
3	Жонш тээвэрлэх үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Төслийн хүрээнд	-	-	-	300.0		ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
		Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох					2000.0		
	Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Далд уурхайн амны агаарын чанарыг хэмжиж аюулгүй ажиллагааг мөрдөх					1500.0		MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”
	Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	MNS4990-2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	Олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 ”
	Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 ”
5	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Аюултай хог хаягдлын цэгийг цаашид засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	-	-	-	3000.0	Үйл ажиллагааны туршид	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-1991 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”, MNS4919-2000 ”
Усан орчин									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	Далд уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэж газрын доорх ус хомсдох	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ;
		Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах (ус шавхах насос, худаг г.м)							MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага;
		Нийт					9300.0		

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны хувьд уурхайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй.

Хүснэгт 27. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2026 онд техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	×	×	×	×	×	×
2	Биологийн нөхөн сэргээлт	2026 онд биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	×	×	×	×	×	×

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2024 онд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хөв цөөрөм байгуулах 9.8 га, мод үржүүлэг ойжуулалт хийх 9.9 га талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан хөв цөөрөм байгуулсан. 2026 онд хөндлөнгийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг төлөвлөсөн.

Хүснэгт 28. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөндлөнгийн булгийн эхийг хашиж хамгаалах	Сумаас санал болгосон.	Төслийн явцад			5.000.0	-	Усны тухай хууль
	Нийт					5000.0		

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Мөнххаан сумын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод үржүүлгийн зориулалтаар 9.9 га талбайг тусгуулан авсан. Энэхүү талбайд энэ жил 7000 ширхэг мод тарихаар төлөвлөсөн. Мөн өмнө жилийн тарьсан модны арчилгаа, тордлогоо хийх ажлын зардлыг тусгаж өгсөн.

Хүснэгт 29. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хийгдэж ажлын тоо хэмжээ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа, он	Нэгжийн зардал Мян.төг	Нийт зардал Мян.төг	Жилд зарцуулах нийт зардал Мян.төг
1	Өмнө тарьсан моддыг арчлах, шилжүүлэх	2026	5000.0	5000.0	

2	7000 хайлаас мод тарих	2026	1.5	10500.0	15500.0
---	---------------------------	------	-----	---------	---------

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хунт-Өгөөж” ХХК-ийн “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн “MV-016689” дугаартай талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгээр 2012 онд археологийн хайгуул, Шинжлэх ухааны академийн Палеонтологийн төвөөр 2013 онд палеонтологийн судалгааны ажил гүйцэтгүүлж дүгнэлт гаргуулсан байна.

Дүгнэлтэд: “Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17.10-т заасны дагуу “Хунт-Өгөөж” ХХК өөрийн эзэмшлийн Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг “Бүдүүн ухаа” хэмээх газарт орших MV-016689 тоот тусгай зөвшөөрөл бүхий ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 337.57 гектар талбайд археологийн хайгуул судалгаа хийлгэх хүсэлт гаргасны дагуу тус хүрээлэнгийн хээрийн судалгааны баг 2012 оны 11 дүгээр сард тухайн талбайд хайгуул судалгаа явуулахад түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй болно. /БОННУ тайлан 2019/

Дүгнэлтэд: Танай компанийн талбайд мезозойн үеийн доод цэрдийн настай зүүнбаян формацын алевролит, аргиллит, гравелит, элсэн чулуулаг, гуу жалга хөндийн дагуу орчин үеийн хурдас болох (голоцен) делюви-пролювийн хурдас чулуулаг тархжээ. Эдгээр хурдсаас палеонтологийн олдвор илрээгүй байна. /БОННУ тайлан 2019/

Далд аргаар жонш олборлох ажлын явцад урьд өмнө үл мэдэгдэж байсан археологийн олдвор эсвэл түүх соёлын дурсгалт зүйлийг олж илрүүлсэн тохиолдолд түүний ойр хавьд ямар ч төрлийн үйл ажиллагаа явуулалгүй уулын ажлыг зогсоох бөгөөд нэн даруй мэргэжлийн байгууллагад хандах арга хэмжээ авч ажиллана.

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс уурхай нь 2026 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Мөн уурхайн кемпэд галын аюулгүй байдлын хор байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 5 000 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 30. Осол эрсдэлийг бууруулах,урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Уурхайнд гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал	Улирал бүр	
2		Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал	Өдөр бүр	
3	Гэнэтийн осол гэмтэл	Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулах	Бүх машин			Үйл ажиллагааны зардал	14 хоног тутамд шалгах	
5	Тэсрэх материалын болон ШТС агуулахын эргэн тойрны галын аюулыг арилгах	Тэсрэх материалын болон ШТС-ын агуулахын эргэн тойрон дох өвс ургамлыг хадаж аюулгүйн зурвас татах	Уурхайн тосгон Тэсрэх материалын агуулах ШТС	2		1000.0	2026 он	
6	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Гамшиг эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Уурхайн болон тэсрэх бодисын агуулах			4000.0	2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль,

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэ х хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
7	Тэсэлгээний ажил болон тэсрэх материалын агуулахтай холбоотой сөрөг нөлөөлөл	Уурхайн тэсэлгээний ажлыг явуулахдаа тэсрэх материалтай харьцах, тэсрэх бодис тээвэрлэх, хадгалах, хураах, устгах ажиллагаанд мөрдөж ажиллах	Тэсрэх материалын агуулах болон тэсэлгээ хийх бүрд	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”,
8		Тэсэлгээний ажлыг мэргэжлийн үнэмлэх бүхий урд нь тэсэлгээ хийж байсан туршлагатай хүмүүсээр хийлгэх	Тэсэлгээний ажил хийх бүрд	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	
		Нийт				5000.0		

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төсөл нь тогтвортой хэрэгжих төсөл учраас хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн аймгийн БОГазраас хог хаягдлыг ангилан ялгах, ангилан ялгасан энгийн болон аюултай хог хаягдлыг дахивар авах цэгт хүргүүлэх ажлыг хийхийг зөвлөсөн. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг яагаад ялгах тухай сургалтыг хийх, мөн уурхайн кемпэд 2 ширхэг ангилан ялгах зориулалттай хогийн савыг суурьлуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Хүснэгт 31. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг ангилах	Уурхайн кемп, ажилчид	3 багц	9 ш	150.0	450.0		Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга
		Уурхайн гал тогооноос гарах	Хоол хүнсний хаягдал			200.0	200.0		
		Ахуйн хог хаягдлыг ангилах сургалт	Уурхайн кемп, ажилчид	Ш	1 удаа	200.0	200.0	Жил бүр	
2.	Аюултай	Аюултай хог хаягдлыг хадгалах талбайг сайжруулах	Хадгалагдсан баттерэй, аккумулятор, тосны шүүр, тосны хаягдал сав, химийн бодисын сав баглаа боодол	Ш			5000.0		Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга
3.	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг	Химийн бодисын	Ш	1	Үйл ажиллагааны зардалд тусгах		Жилд бүр	

		мэргэжлийн байгууллагад шилжүүлж устгуулах	агуулах, баяжуулах үйлдвэр, засврын цех						
4.	хог хаягдлын төлбөрийг Мөнххаан суманд төлөх	Хог хаягдлын төлбөр төлөх	Уурхайн хогийн цэг			Улиралд 660.0	Жилд 2640.0	Улирлаар төлөх	Хог хаягдлын гэрээ
5.	Жорлон, ариун цэврийн өрөө	Ажилчдын ариун цэврийн өрөө, жорлонг Тамир эм бэлдмэлийн ариутгалын бодисоор ариутгах	Жорлон	ш	126	5.0	630.0	Сар бүрийн эхний 10 хоногт	
6.	Шингэн хаягдал	Бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах	Кемпэд				ҮА зардалд тусгах		4943-2015 стандарт
	Нийт						9120.000		

БҮЛЭГ 12. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт байрших “Хунт” ХХК-ийн “Бүдүүн ухаа далд аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаандаа нийт 14 нэр төрлийн химийн бодис, бүтээгдэхүүнийг баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд болон шинжилгээний лабораторид хэрэглэдэг.

Хүснэгт 32. Химийн бодисын эрсдэлийн үнэлгээний менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг 1 жил /мян.төг/	Нийт зардал 5 жил /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Баяжуулах үйлдвэрт ашиглах химийн бодисын эрсдлийн үнэлгээний урьдчилсан тайланг боловсруулах баяжуулах үйлдвэр төслийн 3 дах жилээс ашиглахаар ТЭЗҮ-д тусгагдсан.	Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ хийлгэх			2000.0	Үйл ажиллагааны туршид	“Агаарын тухай” хууль, 2012 MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
Нийт				2000.0		

БҮЛЭГ 13. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг ашиглах” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулав.

Хүснэгт 33. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр


Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар, дуу чимээ						
SO ₂ NO ₂ Нийт тоос PM ₁₀	3 үзүүлэлт 3 байршил	Ажилчдын кемп орчим уурхай орчим Овоолго орчим	Жилд 2 удаа	1 байршил 20 минутын хэмжилт 50.0 мян.төг Нийт 5 байршилд жилд 2 удаа 250.0 мян.төг Нийт 500.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий Шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох Фотоколориметрийн арга MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	PM _{2.5} - 50 мкг/м ³ 24 цаг, 25 мкг/м ³ жил PM ₁₀ - 100 мкг/м ³ 24 цаг, 50 мкг/м ³ жил SO ₂ -20 мкг/м ³ 24 цаг, 10 мкг/м ³ жил NO ₂ -40 мкг/м ³ 24 цаг, 30 мкг/м ³ жил CO-30000мкг/м ³ 1 цаг, 1000 мкг/м ³ 8 цаг

¹ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 05 сарын 06 –ны өдрийн А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний үнэ тариф

						Pb-1 мкг/м3 24 цаг, 0.5 мкг/м3 жил
Усан орчин						
Усны ерөнхий хими,	3 цэгт	Уурхайн усан хангамжийн худаг	Жилд 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ 46000 төг, 3 цэгт *4 удаа* 46.0 төг=552.0 1цэгт * 4 удаа *64=256	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 0900:2018 Ундны усны стандарт MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээж авах, хадгалах, хамгаалах арга MNS 3534-83 (Усны шинжилгээнд зориулж дээж авах) Усны анхан шатны тоо бүртгэл хөтлөх журам Усны тоо бүртгэлийн тайлан гаргах журам	PH-6.5-8.5 NH4-N 0.5 мгN/л, NO2-N 0.2 мгN/л, NO3-N 9.0 мгN/л, PO4-P 0.1 мгP/л , Cl 300мг/л, F 1.5 мг/л, SO4 100мг/л, Mn 0.1 мг/л, Ni 0.01 мг/л, Cu 0.01 мг/л, Mo 0.25, Cd 0.005 мг/л, Co 0.01 мг/л, Pb 0.01 мг/л, As 0.01 мг/л, Cr 0.05 мг/л, Cr6+ 0.01 мг/л, Zn 0.01 мг/л, Hg 0.1 мг/л, Эрдэс тос 0.05 мг/л, фенол 0.001 мг/л, ГИНБ 0.1 мг/л, Benzo(a) pyren 0.005 мкг/л
Хөрсний чанар						
Ялзмаг, рН, давсжилт, P ₂ O ₅ , K ₂ O, Ширхэгийн бүрэлдэхүүн	6 үзүүлэлт * 5 байршил	Ажилчдын кемп орчим уурхай орчим	Жилд 2 удаа	35*6*2=420.0	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS5914:2008	Хар тугалга (Pb) 100, Кадмий (Cd) 3, Мөнгөн ус (Hg) 2, Мишьяк (As) 6,

Хөрсний биологийн бохирдлын үзүүлэлт	2 үзүүлэлт * 2 байршил	Овоолго орчим	Жилд 2 удаа	40.0*6*4=480.0	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт MNS5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5917:2008 Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт, MNS5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага	Хром (Cr) 150, Зургаан валентат хром (Cr6+) 4, Цагаан тугалга (Sn) 50, Стронций (Sr) 800, Ванадий (V) 150, Зэс (Cu) 100, Никель (Ni) 150, Кобальт (Co) 50, Цайр (Zn) 300, Молибден (Mo) 5, Селен (Se) 10, Бор (B) 25, Фтор (F) 200, Цианид (Cn) 25 мг/л, Тиофенол, фенол 4, газрын тосны бүтээгдэхүүн 2 мг/кг
Хөрсний хүнд металлын бохирдол IPC	5 үзүүлэлт * 6 байршил		Жилд 2 удаа	60.0*6*4=720.0		
U, Th K радийн эквивалент	1	Жоншны хүдэр	Жилд 1 удаа	100.0	MNS5626-2006	
НИЙТ ЗАРДАЛ				2476.0		

Зураг 25. Орчны хяналт шинжилгээний дээж авах цэгийн байршил




ДОРНЫН БАЙГАЛЬ ХХК

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт байрлах “Хунт өгөөж” ХХК-ийн ашиглалтын талбай

Орчны хяналт шинжилгээний зураг

Таних тэмдэг

- Зөвшөөрөлтэй талбайн хил
- Хөрсний дээж авсан цэг
- ▲ Усны дээж авсан цэг
- Ургамлын бичиглэл хийсэн цэг
- Агаарын дээж авсан цэг

Координат	
№	Координат
Хөрсний дээж авах цэг	
1	112.829995 47.255893
2	112.823192 47.253677
3	112.818987 47.253043
4	112.808355 47.245046
5	112.822048 47.242408
6	112.819187 47.239627
Усны дээж авах цэг	
1	112.823075 47.256425
2	112.82668 47.25448
3	112.816861 47.25021
4	112.829387 47.248546
5	112.827368 47.245259
Ургамлын бичиглэл хийсэн цэг	
1	112.820391 47.256222
2	112.8266 47.255617
3	112.824151 47.253849
4	112.834118 47.252628
5	112.829387 47.24786
6	112.828562 47.248332
7	112.811946 47.24468
8	112.828612 47.238502
Агаарын дээж авах цэг	
1	112.818355 47.257047
2	112.826622 47.256747
3	112.8299 47.256433
4	112.822257 47.25386
5	112.827773 47.24681

0 0.0750 15 0.3 0.45 0.6

БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 34. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Төслийн нийт хугацаанд	5000.0
4.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Төслийн нийт хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлт
5.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон Сүхбаатар аймгийн БОАЖГ-т хүргэн өгч байх	Жил бүрийн 12 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
7.	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	ҮАЗ
Нийт зардал			5000.0

БҮЛЭГ 15.ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.

Мөнххаан сумын иргэд, Сүхбаатар аймгийн Байгаль орчны газруудад танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 12-р сарын 15-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Мөнххаан сумын ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 35. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Мөнххаан сумын м болон багийн иргэд	ИНХ-д танилцуулах уулзалт	2026 онд хийгдсэн ажил	4 - р улирал	2000.0	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Сүхбаатар аймгийн байгаль орчны газар	БОМтайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу боловсруулж аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр,уулзалт	2026 оны биелэлтийн тайлан 2027 оны БОМтөлөвлөгөө	2026 оны 10-р сар 15-аас 11-р сарын 1	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Сүхбаатар аймаг
3	Төрийн захиргааны төв байгууллага БОАЖЯ-ны ХБОБНУГ	БОМтайлан, БОМтөлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	БОМтайлан дүгнэх хуудасны хамт БОМтөлөвлөгөө г орон нутгийн саналын хамт	2026 оны 12 сарын 15 аас өмнө	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	УБ хот

	Нийт				2000.0		
--	------	--	--	--	--------	--	--

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

“Хунт-Өгөөж” ХХК-ийн “Бүдүүн-Ухаа хайлуур жоншны ордыг ашиглах төсөл” нь Сүхбаатар аймгийн Мөнх-Хаан сумын нутагт орших бөгөөд сумын төвөөс зүүн хойд зүгт 80 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 530 км, Сүхбаатар аймгийн төвөөс баруун хойд зүгт 82 км зайд байрлаж байна.

“Хунт-Өгөөж” ХХК нь Бүдүүн-Ухаагийн хайлуур жоншны ордод 2012 онд хайгуулын ажил гүйцэтгэж ЭБМЗ-ийн 2013 оны 07-р сарын 02-ны өдрийн ХХ-13-07 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2013 оны 08-р сарын 06-ны өдрийн н/319 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэргээр 56.33 % дундаж агуулгатай 193.63 мян.тн хүдэр Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн.

Ордын батлагдсан геологийн нөөцөд тулгуурлан 2013-2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж 56.08 %-ийн дундаж агуулгатай 136.3 мян.тн хүдэр олборлож нөөц багассан тул “Хунт-өгөөж” ХХК өөрийн хөрөнгөөр 2020-2023 онд нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэн ЭБМЗ-ийн 2025 оны 03-р сарын 14-ний өдрийн ХХ-05-04 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2025 оны 05-р сарын 28-ний өдрийн н/46 тоот тушаалаар ордын нөөцийг бодитой ба боломжтой (В+С) зэргээр 60.48 %-ийн дундаж агуулгатай 889.12 мян.тн хүдрийн нөөцийг тодотгон тооцож Улсын нөөцийн нэгдсэн санд шинээр бүртгүүлсэн. Энэхүү нөөцөөс 2024 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж 55.58 %-ийн дундаж агуулгатай 45.09 мян.тн хүдэр олборлосон. Тус олборлосон хүдрийг гар аргаар ангилан ялгаж, МБХЖ-92, МБХЖ-75 маркийн баяжмал, бага агуулгатай хүдэр ялган борлуулсан. Уурхай дээр 2025.01.01-ний байдлаар МБХЖ-92 маркийн 8.44 мян.тн, МБХЖ-75 маркийн 6.71 мян.тн, бага агуулгатай 23.72 мян.тн хүдэр борлуулаагүй үлдсэн.

“Хунт-Өгөөж” ХХК нь тус ордыг 2013-2024 онуудад 1080 м-ийн түвшин хүртэл далд уурхайн аргаар ашигласан. I хүдрийн биетийн дагуу нийт 80 м гүнтэй хоёр босоо гол ам, 80 м квершлаг, 1120 м штрек, 60 м орт, 610 м восстающий малталтуудыг нэвтэрсэн.

Уурхайгаас олборлосон хүдрээ гар аргаар ялгалт явуулна. 2026 онд 50.0 мян.тн хүдэр олборлон гар аргаар ялгалт хийж МБХЖ-92 маркийн 9.0 мян.тн баяжмал, МБХЖ-75 маркийн 12.5 мян.тн баяжмал, бага агуулгатай хүдэр 28.5 мян.тн-ыг ялган авна. Үлдэгдэл бага агуулгатай хүдрийг 2027 оноос флотацын баяжуулах үйлдвэр ашиглалтад орохоор флотацын аргаар баяжуулна. 2026.01.01-ний байдлаар өмнөх онуудын үлдэгдэл 92 %-ийн агуулгатай МБХЖ-92 маркийн 8.4419 мян.тн баяжмал, 75 %-ийн агуулгатай МБХЖ-75 маркийн 6.70525 мян.тн баяжмалыг 2025 онд борлуулна.

Хүснэгт 36. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9300.0
2	Техникийн нөхөн сэргээлтийн зардал	Төлөвлөгдөөгүй
3	Тэрбум мод хөтөлбөр	15500.0
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5000.0
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	5000.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	9120.0
	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2000.0
	Түүх соёлын өвийг хамгаалах менежментийн төлөвлөгөө	500.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	5000.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	2000.0
9	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2476.0
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	55896.0

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **55 896 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож **27 948 000** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай 100900013406 (Төрийн Сан) тоот дансанд байршууллаа.

Хавсралт

2026 оны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр

 ХААН БАНК	Огноо/Date: 2026-04-27 15:45:52			
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information Журналын /Journal No: 27989181 Гүйлгээний дугаар /Poid: 0				
Системийн огноо/System Date: 2026-04-27 15:25:05				
Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number 5041797997	Нэр/Name ХУНТ ӨГӨӨЖ	Дүн/Amount 27,948,000.00 MNT	Ханш/Rate 1.00
Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN190090 000900013406	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН Нэр/Name	27,948,000.00 MNT	1.00
Гүйлгээний утга/Transaction description: ЕВ-ХУНТ ӨГӨӨЖ ХХК 2166831 MV 016689 БО БАРЬЦАА				
Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers				
Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:				
Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:				
Гарын үсэг/Signature:				
Тамга/Stamp:				
_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)				